

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ХУУЛЬ ТОГТООМЖ,  
ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН 2019 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН**

2019.12.19

| Шийдвэрийн<br>Зүйл,<br>заалты                  | Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга | Хэрэгжилтийн явц   | Үнэлгээ, (хүчингү<br>й болсон,<br>хяналтаас<br>хасуулах тухай<br>санал)  | Тасарсан<br>болон<br>удааширч<br>байгаа<br>шалтгаан |   |
|--|--|--|--|---|---|
| 1  | 2                                      | 3  | 4  | 5   | 6 |
| <b>Нэг. Монгол Улсын Шадар сайд</b>            |  |  |  |   |   |
| <b>1.1 Монгол Улсын Засгийн газрын тогтоол</b> |  |  |  |   |   |
| 1.   | 1.                                     | <b>Нийтлэг журам батлах тухай.<br/>2011.11.09 дугаар 311</b><br>2. Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7.2, 8.2.1-д заасны дагуу харьяа байгууллага, аж ахуйн нэгж, өөрийн аппаратад дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журмыг батлан мөрдүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасан. | Төрийн байгууллагуудын Дотоод хяналтын баг 2019 оны төлөвлөгөө гарган баталгаажуулж, хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна. Дотоод хяналт явуулсан ажлын үр дүнд төрийн байгууллагуудын дотоод хяналт сайжирч, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт сайжирч, бичиг баримтын эмх цэгц, албан хэрэг хөтлөлтийн стандарт жигдэрч, төрийн албан хаагчид хувийн хэргээ журмын дагуу бүрдүүлсэн. Байгууллага бүр дотоод хяналтын үйл ажиллагааны тайланг мэдээллийн самбар, цахим хуудсандаа ил тод мэдээлж хэвшсэн. | Бүрэн<br>хэрэгжсэн<br>100%                          |   |
| 2.   | 2.                                     | <b>Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах журам батлах тухай<br/>2011.11.30 дугаар 339</b><br>2.Энэ журмыг хэрэгжүүлж ажиллахыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.  | 2019 оны 03 дугаар сарын 21-ны өдрийн 16.00 цагт Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ЗДТГ-ын урд талбайд мэргэжлийн ангийн 57, албан байгууллага, аж ахуйн нэгжийн 132 албан хаагч бэлэн байдлаа ханган жагссан. Мэргэжлийн ангиуд 1 галын машин, 3 автомашин, 15 мотоцикль, тусгай багаж хэрэгсэлтэй цугларсан. Мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн болон жагссан иргэдэд дээрх тогтоолыг танилцуулж, цагийн байдлын талаар мэдээлэл өгч, аранзны бэлэн байдлыг шалгаж, жагсаалийн бэлтгэлийг зохион байгуулсан.    | Бүрэн<br>хэрэгжсэн<br>100%                          |   |

|    |    |  |   |                      |  |
|----|----|--|---|----------------------|--|
| 3. | 3. | <p><b>Архидан согтуурахтай тэмцэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2017.02.01 дугаар 46</b></p> <p>3. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох журмыг шинэчлэн боловсруулж иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаараа батлуулан хэрэгжүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, уг журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг бүх шатны Засаг дарга нар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Н.Цагаанхүүд тус тус үүрэг болгосугай.</p>  | <p>Архи, согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөлтэй дэлгүүр, үйлчилгээний газрын үйл ажиллагаанд тогтмол хяналт тавин эргүүлийн маршрутанд оруулан, 45 удаа шалгаж гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр анхааруулга, зөвлөмж мэдээллийг өгч ажилласан. Хяналт, шалгалт явуулахад зөрчил гаргасан 4 дэлгүүрт арга хэмжээ тооцсон. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих журам батлах тухай” 2018 оны 07/05 дугаар тогтоолоор зөвлөмж боловсруулан дэлгүүрүүдийн мэдээллийн самбар, хуулийн буланд байршуулж сурталчилан, хэрэгжүүлсэн. 2019 онд тусгай зөвшөөрлийн хугацаа сунгуулах хүсэлт гаргасан 5 иргэний материалыг хүлээн авч, хянан баталгаажуулж, аймгийн зөвлөлд хүргүүлж, тусгай зөвшөөрлийг олгосон.</p> | Бүрэн хэрэгжсэн 100% |  |
| 4. | 4. | <p><b>Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх, таниулах өдөртэй болох тухай 2017.03.07 дугаар 67</b></p> <p>1. Жил бүрийн 3 дугаар сарын 4 дэх Лхагва гарагийг “Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх, таниулах өдөр” болгон зарласугай.</p> <p>2. “Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх, таниулах өдөр”-ийг газар хөдлөлтийн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах, аврах үйл ажиллагаанд хүн амыг сургаж бэлтгэх, таниулах ажил зохион байгуулан жил бүр улс даяар тэмдэглэн өнгөрүүлж байсугай.</p> | <p>2019 оны 03 дугаар сарын 20-нд сумын Онцгой комиссоос мэргэжлийн ангиуд болон иргэдэд Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах чиглэлээр яриа таниулга хийж шийдвэрийг сурталчилсан. Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх гарын авлага 200 ширхэгийг бэлтгэн иргэдэд тараасан.</p>  | Бүрэн хэрэгжсэн 100% |  |
| 5. | 5. | <p><b>Агаарын хэт халалт, хуурайшилттай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2017.07.16 дугаар 205</b></p>   | <p>Түймэрийн аюултай үеүүдэд түймэрээс урьдчилан сэргийлж нөхөрлөл, ААН, иргэдэд 4 удаа сургалт зохион байгуулсан. Сургалтанд нөхөрлөл, ААНэгжийн давхардсан тоогоор 300 орчим иргэн</p>  | Бүрэн хэрэгжсэн 100% |  |

|  |    |  |   |                         |  |
|--|----|--|---|-------------------------|--|
|  |    | а/ ой, хээрийн бүсэд аялал, зугаалга зохион байгуулахыг хязгаарлаж, орон нутгийн байгаль хамгаалагч, цагдаагийн алба хаагчдын хамтарсан эргүүл, харуул гарган ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, сэрэмжлүүлэх чиглэлээр хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Оюунхорол, бүх шатны Засаг дарга нарт;  | хамрагдсан. Мөн багийн ИНХурлуудад мэдээлэл хийж ойн түймэрээс урьдчилан сэргийлэх, асаасан гал, нурам, цогоо бүрэн унтрааж байх санамж бичиг, сэрэмжлүүлэгийг 300 ширхэг хийж иргэдэд тараасан. Байгаль хамгаалах нөхөрлөлүүдээс түймэр гаргахгүй байх баталгаа гаргуулж, эргүүл, хяналтын ажлыг сайжруулах үүрэг даалгавар өгч хамтран ажиллаж байна. Үүний үр дүнд 2019 онд ой хээрийн түймэр гаргаагүй.   |                         |  |
| 6.   | 6. | <b>Гамшиг, галын аюулгүй байдлыг хангуулах талаар авах зарим арга хэмжээний тухай 2018.04.06 дугаар 68</b><br>3. Дээрх арга хэмжээний хэрэгжилтийг эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллага болон хувийн хэвшлийн оролцоонд түшиглэн шуурхай зохион байгуулж, хэрэгжилтийн талаарх дүн, мэдээг онцгой байдлын асуудал хариуцсан байгууллагад заасан хугацаанд гаргаж өгөх ажлыг шуурхай зохион байгуулж ажиллахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга нарт даалгасугай. | Гамшиг, гал түймрийн аюул, ослоос урьдчилан сэргийлэх бэлэн байдлын шаардлагыг өндөржүүлэх, болзошгүй гал түймрийн аюул, ослоос хүний амь нас, эд хөрөнгийг авран хамгаалж, гал унтраах машинаар 1 гэр, 2 байшин болон рамьн үртэс 3 удаа шатахад галыг унтрааж, наадмын талбайн зүлэгжүүлэлтэд усалгаа хийж үр дүнтэй ашиглаж байна. Сумын Засаг даргын 2019 оны а/27 дугаар захирамжаар “Гамшгаас хамгаалах болон гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсгийг байгуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр хангасан. | Бүрэн хэрэгжсэн<br>100% |  |
| <b>Дундаж үнэлгээ</b>  |    |  |   | <b>100%</b>             |  |
| <b>Хоёр. Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга</b> |    |  |   |                         |  |
| <b>2.1. Ерөнхийлөгчийн зарлиг</b>  |    |  |   |                         |  |

|  |    |   |  |                                 |  |
|--|----|---|--|---------------------------------|--|
| 7.   | 7. | <p><b>Нутаг орны газар зүйн нэрийг хамгаалах тухай</b><br/> <b>2017.07.10 дугаар 186</b></p> <p>1. Монгол Улсын Их Хурлын 2003 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 42 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын нутаг дэвсгэрийн газар зүйн нэрийн жагсаалт” дахь газар усны газар зүйн нэрийг албан хэрэг, олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд мөрдүүлэх, тухайн орон нутагтаа ард иргэдийн дунд сэргээн хэвшүүлэх, цаашид хууль бусаар газар орны нэр өөрчлөх гэмт явдалтай хууль тогтоомжийн дагуу тууштай тэмцэхийг бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай.</p> <p>2. Уул ус, газар нутгаа эрх бүхий байгууллагаас баталсан нэрээр зөв нэрлэж занших, өөрчлөн буруу нэршихээс сэргийлэх, монгол хэлнээс бусад хэлээр орчуулах буюу бусад хэлний дуудлагаар галиглахгүй байхыг Монгол Улсын нийт иргэд, байгууллагад уриалсугай.</p> | <p>Монгол Улсын Их Хурлын 2003 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 42 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын нутаг дэвсгэрийн газар зүйн нэрийн жагсаалт” дахь газар усны газар зүйн нэрийг албан хэрэг, олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд мөрдүүлэх, таниулах зорилгоор бүх байгууллагуудад албан бичиг хүргүүлж, биелэлтэд хяналт тавин ажилласан. Мөн уул ус, газар нутгаа эрх бүхий байгууллагаас баталсан нэрээр зөв нэрлэж занших, өөрчлөн буруу нэршихээс сэргийлэх, монгол хэлнээс бусад хэлээр орчуулах буюу бусад хэлний дуудлагаар галиглахгүй байхыг албан байгууллагууд болон аж ахуйн нэгж, иргэдэд уриалж, хэрэгжүүлэн ажиллаж байна.</p> | <p>Бүрэн хэрэгжсэн<br/>100%</p> |  |
| <b>2.2 Монгол Улсын Засгийн газрын тогтоол</b> |    |   |  |                                 |  |
| 8.   | 8. | <p><b>Иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай</b><br/> <b>2005.04.01 дугаар 67</b></p> <p>1.б/. иргэдээс амаар, бичгээр болон цахим сүлжээ, радио, телевизээр явуулж байгаа шууд нэвтрүүлгээр, түүнчлэн тусгайлан ажиллуулсан утсаар дамжуулан ирүүлсэн өргөдөл, гомдлын талаар гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг шалгах, шийдвэрлэлтийн явцыг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлэх, хууль тогтоомжоор тогтоосон өөрийн эрхлэх асуудлын хүрээг нийтэд зарлан сурталчлах зэрэг ажлыг дээрх журамд тусган хэрэгжүүлэх арга хэмжээ авах</p>   | <p>Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд бичгээр 191 өргөдөл ирж холбогдох байгууллага, албан тушаалтнуудад шуурхай хүргэн 186 өргөдлийг хугацаанд нь шийдвэрлэсэн. Шийдвэрлэх хугацаа болоогүй 5 өргөдөл байгаа. Өргөдөл, гомдлыг төрлөөр нь авч үзвэл: Ажилд орохыг хүссэн-76, тэтгэвэр, тэтгэмж тогтоолгохыг хүссэн 78, бусад 37 өргөдөл ирсэн байна. Иргэдээс ирүүлсэн өргөдөлүүдээс тэтгэвэр, тэтгэмж тогтоолгох өргөдөл 40%-ийг буюу дийлэнх хувийг эзэлж байна.</p> <p>Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн мэдээллийг сумын цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулж хэвшсэн.</p>   | <p>Бүрэн хэрэгжсэн<br/>100%</p> |  |
|  | 9. | <p>1.в/. иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдолд тусгагдсан асуудлуудыг өөрийн байгууллагын</p>  | <p>Аялал жуулчлалын зориулалтаар эко гэр ажиллуулах хүсэлт гаргасан иргэний өргөдөлд сумын Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу гэрээ байгуулж</p>  |                                 |  |

|     |     |   |   |                         |  |
|-----|-----|---|---|-------------------------|--|
|     |     | хэрэгжүүлэх бодлого, авах арга хэмжээнд тусган ажиллах  | газрыг олгосон. Жуулчны бааз байгуулах иргэний хүсэлтийг ОХБЦГ-ын хамгаалалтын захиргаанд уламжлан шийдвэрлэсэн. Хогийн цэгийг нүүлгэн шилжүүлэх тухай иргэдийн санал, мөн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан гол шийдвэрлэх асуудлуудын нэг болох хог хаягдлыг багасгах, хог цэгийн нүүлгэх асуудлыг багийн иргэдийн нийтийн хурал, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцэж шийдэлд хүрсэн. | Бүрэн хэрэгжсэн<br>100% |  |
|     | 10. | 3.Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаанд хамаарах асуудлаар иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг ИТХ-д шилжүүлэн шийдвэрлүүлж, дүнг нэгтгэн улирал, хагас, бүтэн жилийн мэдээлэлд оруулж байх  | Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаанд хамаарах асуудлаар иргэд, байгууллагаас өргөдөл, гомдол ирээгүй. Төрийн байгууллагуудад ирсэн өргөдөл гомдлыг сумын хэмжээнд нэгтгэн холбогдох газарт хугацаанд нь мэдээлж байна.   | Бүрэн хэрэгжсэн<br>100% |  |
| 9.  | 11. | <b>Аргачлал шинэчлэн батлах тухай 2018.01.24 дугаар 20</b><br>2.Аргачлал батлагдсантай холбогдуулан хөгжлийн индекс тооцоход шаардагдах мэдээллийг дараа оны 2 дугаар сард багтаан “Орон нутгийн хөгжлийн индекс тооцох цахим мэдээллийн систем”-д оруулан баталгаажуулж байхыг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч болон аймаг, сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай. | Орон нутгийн хөгжлийн индекс тооцох аргачлалыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж, шаардлагатай мэдээллийг бэлдэж 2019 оны 2 дугаар сарын 25-нд “Орон нутгийн хөгжлийн индекс тооцох цахим мэдээллийн систем”-д баталгаажуулж оруулсан.   | Бүрэн хэрэгжсэн<br>100% |  |
| 10. | 12. | <b>Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт батлах тухай. 2009.05.14 дугаар 143</b><br>2. “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт”-ийг хангах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүн, Засгийн газрын агентлагийн дарга, бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай.   | Суманд хийгдэж байгаа бүтээн байгуулалтын ажил, үйл ажиллагааны мэдээллийг багийн ИНХурлуудад тогтмол мэдээлж, <a href="http://Batulzii.ov.gov.mn">Batulzii.ov.gov.mn</a> цахим хуудсанд байршуулж байна.   | Бүрэн хэрэгжсэн<br>100% |  |
| 11. | 13. | <b>Журам батлах тухай 2017.04.12 дугаар 111</b><br>1. “Цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөх нийтлэг журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.  | ЗДТГазар, ЕБСургууль Архив, албан хэрэг хөтлөлтийн ORG-RMS программыг суулган нэвтрүүлэн албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд ашиглаж байна. 2018 оны захирамжлалын 4 хадгаламжийн нэгжийг скайнардэж PDF файл үүсгэж, цахим архивт   |                         |  |

|     |     |  |  |                         |  |
|-----|-----|--|--|-------------------------|--|
|     |     | 2. Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан журмын хэрэгжилтийг зохион байгуулан мэргэжил, арга зүйн заавар, аргачлалаар хангаж ажиллахыг Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга Б.Чинбатад, журмыг эрхлэх ажлынхаа хүрээнд үе шаттайгаар нэвтрүүлэн үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай. | шилжүүлсэн. ЗДТГ-ын албан хаагчид баримт бичгийн 3 жилийн мэдээллийн цахим сантай болсон.  | Бүрэн хэрэгжсэн<br>100% |  |
| 12. | 14. | <b>Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай</b><br><b>2018.08.22 дугаар 258</b><br>1.1. харьяа байгууллага болон салбар, нэгжид сахилга, дэг журмыг сахиулах тодорхой арга хэмжээ авч, төрийн албаны хууль тогтоомж, холбогдох дүрэм, журмыг зөрчсөн төрийн албан хаагчид хариуцлага тооцож тухай бүр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тайлагнаж байх;         | Төрийн жинхэнэ албан хаагч, төрийн үйлчилгээний албан хаагчдийн ёс зүй, сахилга хариуцлагыг сайжруулахад онцгой анхаарч сумын ЗДТГазар, бусад төсвийн байгууллагад орон тооны бус 5 ёс зүйн зөвлөлд 20 гаруй төрийн албан хаагч ажиллаж, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг бүх ажилтан, албан хаагчдад танилцуулж, баталгаа гаргуулж, дотооддоо ёс зүйн сургалтыг 1-2 удаа зохион байгуулж, байгууллага бүр ёс зүйн хариуцлагыг өндөржүүлж ажилласан.<br>2019 онд ажлын хариуцлага алдсан 1 албан хаагчид цалингийн арга хэмжээ тооцсон. | Бүрэн хэрэгжсэн<br>100% |  |
|     | 15. | 1.4. төрийн жинхэнэ албан тушаалд сул орон тоо гарсан тохиолдолд тухайн байгууллага болон төрийн холбогдох байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдаас үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингээр шалгаруулж нөхөн томилох замаар төрийн мэргэшсэн албыг бэхжүүлэх;  | 2019 он гарсаар ЗДТГазрын Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтний 2 сул орон тоо гарсан бөгөөд сул орон тооны захиалгыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд хүргүүлсэн.  | Хэрэгжих шатанд<br>100% |  |
|     | 16. | 1.6. төрийн жинхэнэ албан хаагч жирэмсний болон амаржсаны амралттай байгаа, эсхүл 3 сараас дээш хугацааны сургалтад хамрагдаж сул орон тоо гарснаас бусад тохиолдолд төрийн албаны сул орон тоонд гэрээт ажилтан томилохгүй байх зарчим баримталж, төрийн байгууллагад албан ажлын зайлшгүй шаардлагыг үндэслэн богино хугацаагаар   | Тайлант хугацаанд 2 сул орон тоо гарч, сул орон тоонд томилсон тушаал гараагүй.  | Бүрэн хэрэгжсэн<br>100% |  |

|     |  |   |                      |  |
|-----|--|---|----------------------|--|
|     | ажиллуулахаас бусад тохиолдолд гэрээт ажилтан ажиллуулахгүй байх;  |   |                      |  |
| 17. | 1.7. төрийн албан хаагч албан томилолтын явцад, ажлын болон ажлын бус цагаар ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх явдлыг таслан зогсоох, төрийн байгууллагын байр, ажлын байранд согтууруулах ундаа, мансууруулах бодис, галт болон хүйтэн зэвсэг, тэсэрч дэлбэрэх болон шатамхай бодис, хэрэгслийг нэвтрүүлэх, хадгалах, хэрэглэх, ашиглахыг байгууллагын дотоод журамд тусган хориглож, зөрчсөн тохиолдолд хариуцлага тооцох; | Байгууллагын дотоод журам, жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, албан хаагчдын ажлын байрны тодорхойлолт, үр дүнгийн болон хөдөлмөрийн гэрээнд сахилга хариуцлага, ёс зүйг сайжруулах, төрийн албан хаагч албан томилолтын явцад, ажлын болон ажлын бус цагаар ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх явдлыг таслан зогсоох, төрийн байгууллагын байр, ажлын байранд согтууруулах ундаа, мансууруулах бодис, галт болон хүйтэн зэвсэг, тэсэрч дэлбэрэх болон шатамхай бодис, хэрэгслийг нэвтрүүлэх, хадгалах, хэрэглэх, ашиглахыг хориглох чиглэлээр зорилт, арга хэмжээг тусган хэрэгжүүлж байна. | Хэрэгжих шатанд 70%  |  |
| 18. | 1.8. төрийн албан хаагчдын үйлдсэн гэмт хэрэг, гаргасан зөрчил, сахилга, ёс зүйн зөрчилд судалгаа, дүн шинжилгээ хийж, шалтгаан нөхцөлийг тогтоон, урьдчилан сэргийлэх арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах;  | ГХУСАЗ салбар зөвлөл, ЗДТГазар хамтран төрийн албан хаагчдад Төрийн албаны тухай шинэчилсэн хууль, Засгийн газрын “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 2017 оны 01 дүгээр албан даалгаварыг хэрэгжүүлэх, Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай 2018 оны 258 дугаар тогтоол, Эрүүгийн хуулийн албан тушаалын гэмт хэргийн хор уршгийн талаар сургалт, сурталчилгаа зохион байгуулж, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлсэн.   | Бүрэн хэрэгжсэн 100% |  |
| 19. | 1.9. төрийн байгууллагад ажлын цаг ашиглалтыг хурууны хээний болон камерын хяналтын системээр байнга бүртгэж, түүнд тавих хяналтыг сайжруулах;   | Засаг даргын зөвлөлийн хурлаар байгууллагын дарга, эрхлэгч нарт цагийн бүртгэлийг сайжруулах, цаг бүртгэлийг цахим хэлбэрт шилжүүлэх үүрэг чиглэл өгч, одоогийн байдлаар ЗДТГазар цаг бүртгэлийг цахимаар болон камерийн хяналтын системээр бүртгэж, бусад байгууллагууд бүртгэлийн дэвтэр болон хяналтын камераар бүртгэж байна.   | Хэрэгжих шатанд 70%  |  |
| 20. | 1.10. ажлын байран дахь бүх хэлбэрийн хууль бус дарамт шахалт, ялгавартай хандах үйлдлийг таслан зогсоож, ийм үйлдэл гаргасан албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагын талаар  | Төрийн албан хаагчид төрийн бодлого шийдвэрийг иргэдэд хуулийн дагуу түргэн шуурхай хүргэж, ажлын байран дахь бүх хэлбэрийн хууль бус дарамт шахалт,  | Бүрэн хэрэгжсэн 100% |  |

|     |     |   |  |                      |  |
|-----|-----|---|--|----------------------|--|
|     |     | байгууллагын дотоод журамд тусган мөрдүүлж, эерэг уур амьсгалтай, сэтгэл зүйн дарамтгүй ажиллах орчныг бүрдүүлэх арга хэмжээ авах;  | ялгавартай хандах үйлдэл гаргалгүй ажиллаж байна. Энэ талаар байгууллагын дотоод журамд тусгасан.  |                      |  |
|     | 21. | 3. Төрийн албаны соёл, дэг журмыг сахиулах, ажлын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор гэнэтийн болон төлөвлөгөөт хяналт шалгалтыг холбогдох байгууллагатай хамтран төрийн байгууллагуудад тогтмол зохион байгуулж байхыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатар, өөрийн эрхлэх асуудлын хүрээний Засгийн газрын агентлаг, төрийн бусад байгууллагад хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дарга нарт тус тус даалгасугай. | Өвөрхангай аймгийн Засаг даргын Тамгын газраас хяналт шинжилгээ, үнэлгээний ажлын хэсгийн бүрэлдэхүүн бүх байгууллагыг хамруулан хяналт, шалгалтын ажлыг зохион байгуулж, зөвлөн туслах үйлчилгээг үзүүлсэн. Зөрчил, дутагдлыг арилгаж, цаашдынхаа ажилд мөрдлөг болгон ажиллаж байна.   | Хэрэгжих шатанд 70%  |  |
| 13. | 22. | 2019 оныг “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил” болгох тухай<br>2019.01.16 дугаар 23<br>3. “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил”-ийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг эрхлэх ажлын хүрээ, харьяа нутаг дэвсгэртээ зохион байгуулж, ажлын тайланг улирал тутам Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлж байхыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.   | “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил”-ийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг гарган баталгаажуулж, хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна. Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал, шилэн дансны мэдээллийг хугацаанд нь тогтмол мэдээлж, хяналт, хариуцлагыг сайжруулж, төрийн үйлчилгээг иргэнд хүргэх чиг үүрэг бүхий байгууллага өөрийн үйл ажиллагаандаа мөрдөж байгаа дүрэм, журам, үйлчилгээний ажилтны чиг үүрэг, эрх хэмжээ, үйлчилгээ үзүүлэх хугацаа, бүрдүүлэх шаардлагатай материал зэрэг мэдээллийг сумын цахим хуудсанд байршуулсан. | Бүрэн хэрэгжсэн 100% |  |
| 14. | 23. | Дүрэм батлах тухай<br>2019.01.23 дугаар 33<br>2. Байгууллагын дотоод журмыг энэ тогтоолоор баталсан дүрэмд нийцүүлэн баталж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг төсвийн шууд захирагч нарт даалгасугай.  | Төрийн жинхэнэ албан хаагч, төрийн үйлчилгээний албан хаагчдийн ёс зүй, сахилга хариуцлагыг сайжруулахад онцгой анхаарч сумын ЗДТГазар, бусад төсвийн байгууллагад орон тооны бус 5 ёс зүйн зөвлөлийг шинэчлэн байгуулж, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг бүх ажилтан, албан хаагчдад танилцуулж, баталгаа гаргуулж, дотооддоо ёс зүйн  | Бүрэн хэрэгжсэн 100% |  |



|     |     |   |   |                         |  |
|-----|-----|---|---|-------------------------|--|
|     |     |   | сургалтыг зохион байгуулж, байгууллага бүр ёс зүйн хариуцлагыг өндөржүүлж ажилласан. 2019 онд ажлын хариуцлага алдсан 1 албан хаагчид цалингийн арга хэмжээ тооцсон байна.  |                         |  |
| 15. | 24. | <p>2019 оныг “Эх оронч худалдан авалтын жил” болгох тухай<br/>2019.01.30 дугаар 59<br/>3. Энэ тогтоолын 2 дугаар зүйлд заасан төлөвлөгөөнд тусгасан ажлын хүрээнд нарийвчилсан төлөвлөгөө гаргаж, эрхэлсэн салбар, харьяа нутаг дэвсгэртээ хэрэгжилтийг зохион байгуулж, тайланг хагас болон жилийн эцсийн байдлаар Аж үйлдвэржилтийн бодлогын зөвлөлд хүргүүлэхийг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад үүрэг болгосугай.<br/>4. “Эх оронч худалдан авалтын жил”-ийн хүрээнд дотоодод үйлдвэрлэсэн үндэсний бараа, бүтээгдэхүүнийг худалдан авч хэрэглэхийг нийт аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд уриалсугай.</p> | <p>Засгийн газраас хэрэгжүүлж буй энэхүү бодлогын хүрээнд дотоодын үйлдвэр эрхлэгчдийг үйлчлүүлэгчтэй холбох, бараа бүтээгдэхүүнийг танилцуулах “Эх оронч худалдан авалт-Үндэсний үйлдвэрлэл-2019” үзэсгэлэнг 2019 оны 1 дүгээр сарын 21, 22-ны өдрүүдэд, мөн Алтан намар үзэсгэлэн худалдааг 10 дугаар сард тус тус зохион байгууллаа. Үзэсгэлэнд 28 үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч оролцон үүний үр дүнд жижиг, дунд үйлдвэрлэгчдийн үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнийг дотооддоо түлхүү худалдан авах нөхцөл, боломжийг бүрдүүлж өглөө. Үзэсгэлэнд дотооддоо үйлдвэрлэсэн цагаан идээ, дээл, хантааз, малгай, зөгийн бал, шар сүүний бүтээгдэхүүн, хэвийн боорцог, тахилын таваг, гоёл чимэглэл, суран эдлэлийн бүтээгдэхүүнээр оролцож нийт 10.5 сая төгрөгийн борлуулалт хийсэн.</p> | Бүрэн хэрэгжсэн<br>100% |  |
| 16. | 25. | <p>Төрийн үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай<br/>2019.04.17. дугаар 149<br/>3. Иргэн, хуулийн этгээдэд төрийн зарим үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхэд төрийн мэдээллийн сангаас гарах боломжтой лавлагаа, мэдээллийг шаардахгүй байх зарчмыг баримтлан технологийн дэвшлийг ашиглаж төрийн мэдээлэл солилцооны “ХУР” системд хандан авах замаар шийдвэрлэх, “Үйлчилгээний нэгдсэн төв”-д ажиллах байгууллагын албан хаагчдын орон тооны дээд хязгаарыг батлагдсан төсөвтөө багтаан шийдвэрлэхийг холбогдох сайд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга</p>  | <p>Улсын бүртгэлийн үйлчилгээ, нийгмийн халамжийн үйлчилгээ, банк, санхүүгийн байгууллагууд иргэн, хуулийн этгээдэд төрийн зарим үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхэд төрийн мэдээллийн сангаас гарах боломжтой лавлагаа, мэдээллийг шаардахгүй байх зарчмыг баримтлан технологийн дэвшлийг ашиглаж төрийн мэдээлэл солилцооны “ХУР” системд хандан мэдээллийг түргэн шуурхай авч төрийн үйлчилгээг үзүүлж байна.</p>   | Бүрэн хэрэгжсэн<br>100% |  |

|   |     |  |   |                      |  |
|---|-----|--|---|----------------------|--|
|   |     | нарт даалгаж, Шүүхийн ерөнхий зөвлөл (Н.Лүндэндорж)-д зөвлөсүгэй.  |   |                      |  |
| <b>2.3. Монгол Улсын Засгийн газрын албан даалгавар</b> |     |  |   |                      |  |
| 17.   | 26. | <p><b>Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай</b><br/> <b>2017.10.26 дугаар 01</b></p> <p>1. Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлагын дарга, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагуудад:</p> <p>1.1. Иргэндээ ээлтэй хуулийн засаглалыг бэхжүүлэх: Төрийн бүх шатны байгууллагын албан хаагчид шударга ёс, хууль дээдлэх зарчим баримтлан, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, улс төрөөс ангид, мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвартай ажиллах.</p> | Төрийн жинхэнэ албан хаагч, төрийн үйлчилгээний албан хаагчдийн ёс зүй, сахилга хариуцлагыг сайжруулахад онцгой анхаарч сумын ЗДТГазар, бусад төсвийн байгууллагад орон тооны бус 5 ёс зүйн зөвлөлийг шинэчлэн байгуулж, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг бүх ажилтан, албан хаагчдад танилцуулан, баталгаа гаргуулж, дотооддоо ёс зүйн сургалтыг зохион байгуулж, байгууллага бүр ёс зүйн хариуцлагыг өндөржүүлж ажилласан. 2019 онд ажлын хариуцлага алдсан 1 албан хаагчид цалингийн арга хэмжээ тооцсон байна.                     | Бүрэн хэрэгжсэн 100% |  |
|   | 27. | <p>1.2. Авлигын хяналтыг сайжруулах: Төрийн албыг хувийн ашиг сонирхлын хэрэгсэл болгох гэсэн оролдлогыг тухай бүр нь таслан зогсоож, авлига, хээл хахууль, хүнд суртал, шударга бус байдалтай шат шатандаа тууштай тэмцэх.</p>  | Авлигатай тэмцэх, авлигын эсрэг сумын нэгдсэн төлөвлөгөөг боловсруулан сумын Засаг даргаар батлуулж хэрэгжүүлсэн. Авлигын эсрэг хуулийг төрийн албан хаагчдад сурталчлан, Нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангуулж, авлигад өртөх эрсдэл бүхий ажил, албан тушаалын жагсаалт, судалгааг гарган хяналт тавин ажиллаж, байгууллагуудын дотоод журамд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр заалт оруулж батлан мөрдүүлж байна. | Бүрэн хэрэгжсэн 100% |  |
|   | 28. | <p>1.3. Иргэдээ сонсож, төрийн албаны хариуцлагыг өндөржүүлэх: “Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах төв”-д иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шуурхай нягтлан шалгаж, асуудлыг шийдвэрлэн дутагдал гаргасан холбогдох албан тушаалтанд тухай бүр хариуцлага тооцож ажиллах.</p>   | Иргэдээ сонсож, багийн Иргэдийн нийтийн хурлуудаар иргэдийн санал, хүсэлт, төрийн байгууллагуудын үйлчилгээний талаар сэтгэл ханамжийн судалгаа авч нэгтгэн дүгнэлт гарган ажиллаж байна. Нийт 200 иргэнээс санал, хүсэлт авсан. Иргэдээс гарсан саналуудыг эрэмбэлэн бодлого шийдвэртээ тусган хэрэгжүүлж, дутагдалтай ажиллаж байгаа албан хаагчдад хурлаар хугацаатай үүрэг даалгавар өгч, биелэлтийг дүгнэн ажилласан.  | Хэрэгжих шатанд 70%  |  |

|  |     |   |  |                         |  |
|--|-----|---|--|-------------------------|--|
|  | 29. | 1.4. Төрийн албаны үр ашгийг сайжруулах: Ажилтан, албан хаагчдын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг сайжруулах, үүрэгт ажлаа чанартай, үр дүнтэй хийж гүйцэтгэн, ажлын байрны дэг журмыг чанд сахих.  | Төрийн байгууллагуудын ажилтан, албан хаагчдын цаг ашиглалт, ажлын үр дүн, бүтээмж, гүйцэтгэлийн байдалд хяналт, үнэлгээ хийж, дүгнэлт гаргахад ажлын цаг ашиглалт дутагдалтай байсан тул цагийн бүртгэлийг сайжруулах үүрэг чиглэл өгч, хяналт тавин ажиллаж байна. Суманд ажиллаж байгаа нийт төрийн албан хаагчид ажлын байрны дэг журмыг чанд сахиж, үр дүнтэй ажиллаж байна.  | Бүрэн хэрэгжсэн<br>100% |  |
|  | 30. | 1.5. Бодлогын тогтвортой байдлыг хангах: Төрийн бодлогын залгамж чанар, тогтвортой байдлыг хангаж, төрийн албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах, төрийн мэргэшсэн албыг бэхжүүлэх.  | Төрийн албанд нийт 260 албан хаагч ажиллаж, төрийн бодлогыг хэрэгжүүлэн, тогтвор суурьшилтай, ажлын байранд мэргэжлээ дээшлүүлж, төрийн залгамж чанарыг бэхжүүлэн тасралтгүй ажиллаж байна. Сургуулийн өмнөх боловсролын байгууллага, ЕБСургуулийн мэргэжлийн багшийн хангалт 100 хувь хангагдсан. Эрүүл мэндийн төвийн хувьд их эмчийн дутагдалтай байгааг холбогдох газарт уламжлан шийдвэрлэсэн.  | Бүрэн хэрэгжсэн<br>100% |  |
| <b>Дундаж үнэлгээ</b>                              |     |   |  | <b>95.2%</b>            |  |
| <b>Гурав. Байгаль орчин, аялал жуулчлалын сайд</b> |     |   |  |                         |  |
| <b>3.1 Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг</b>      |     |   |  |                         |  |
| 18.  | 31. | <b>Мод тарих үндэсний өдөр зарлах тухай 2010.04.14 дугаар 63</b><br>1. жил бүрийн 5,10 дугаар сарын хоёр дахь долоо хоногийн “Бямба” гарагийг бүх нийтээр мод тарих үндэсний өдөр болгон зарласугай.<br>2. Мод тарих үндэсний өдөр бүх нийтээр мод, бут, сөөг, цэцэг тарих, цаашид арчлан хамгаалах, түүнийгээ амьдралын хэв маяг болгон хэвшүүлэн сурталчилж ажиллахыг Монгол Улсын нийт ард иргэд, айл өрх, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, хандивлагч нарт уриалсугай. | Төв суурин газрын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор бүх нийтээр “Мод тарих үндэсний” өдрийг хавар, намар зохион байгуулж, 2019 оныг аймгийн ИТХурлаас Тохижилт ногоон байгууламжийг нэмэгдүүлэх жил болгож зарласантай холбогдуулж сумын хэмжээнд мод тарих, орчны тохижилтийн ажлууд хийгдсэн.<br>Мод тарих өдрүүдийг угтаж мод бут, сөөг тарьж ургуулах, ногоон байгууламжид тарьсан мод бутыг услах арчлах, хамгаалах, танаж хэлбэржүүлэх ажлыг зохион байгуулж, мод тарих аргачлал зөвлөмжийг иргэдэд тарааж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилсан.<br>2019 онд мод тарих арга хэмжээнд нийт 10 аж ахуйн нэгж, байгууллага, 315 иргэн оролцож 625 ширхэг мод, 6890 ширхэг бут сөөг буюу нийт 7515 ширхэг мод | Бүрэн хэрэгжсэн<br>100% |  |

|  |     |  |  |                         |  |
|--|-----|--|--|-------------------------|--|
|  |     |  | бут тарьсан байна. “Ногоон байгууламж байгуулах, мод, сөөг тарих арга зүй” сэдэвт сургалтыг 2019 оны 05 сарын 20-ны өдөр Соёлын төвд зохион байгуулсан. Сургалтанд мод тарих хүсэлтэй нөхөрлөл, аж ахуйн нэгжийн төлөөлөл нийт 70 гаруй иргэн хамрагдсан.  |                         |  |
| 19.  | 32. | <b>Засгийн газарт чиглэл өгөх тухай. 2013.11.25 дугаар 178</b><br>1. Нийслэл Улаанбаатар хотод Үндэсний цэцэрлэгт хүрээлэнг, хот тосгон, аймаг, сумдын төвд цэцэрлэгт хүрээлэн байгуулах, тэдгээрийг сэргээн засварлаж тохижуулахыг,   | Сумын Цэцэрлэгт хүрээлэнд тарьсан модны ургалт 100-200 см өндөр ургалттай.<br>2019 онд Орон нутгийн хөгжлийн сангийн 36.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар сумын төвийн цэцэрлэгт хүрээлэнг сэргээн засварлаж, хүүхэд, залуучууд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн.   | Бүрэн хэрэгжсэн<br>100% |  |
| <b>3.2 Монгол Улсын Засгийн газрын тогтоол</b> |     |  |  |                         |  |
| 20.  | 33. | <b>Ойн хөнөөлт шавьжтай тэмцэх хөрөнгийн тухай 2002.05.01 дугаар 81</b><br>2. Ойн хөнөөлт хортон шавьжтай тэмцэх ажилд шаардагдах хүч хэрэгслийг нэмэгдүүлэх, техник, материалаар хангах арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэн энэхүү ажлыг хүн, мал, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй арга хэлбэрээр зохион байгуулах            | 2019 оны 06 дугаар сард улсын төсвийн хөрөнгөөр Ой судалгаа, хөгжлийн төв УТУГазар, Сум дундын ойн анги, Байгаль орчны хяналтын улсын байцаач, байгаль хамгаалагч нар хамтран 40000 га талбайд ойн хортон шавьжны судалгааг хийж гүйцэтгэлээ. Сумын ойн санд голомт байхгүй, дархалттай гэсэн дүгнэлт гарсан.  | Бүрэн хэрэгжсэн<br>100% |  |
| 21.  | 34. | <b>Журам батлах тухай 2009.07.22 дугаар 227</b><br>2. Ойн сангийн тодорхой хэсгийг энэхүү журмын дагуу нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад гэрээгээр эзэмшүүлэх замаар ойн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх, зохистой ашиглах ажлын үр өгөөжийг дээшлүүлэх арга хэмжээ авахыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт үүрэг болгосон. | Суманд 27 нөхөрлөл ойн санг гэрээгээр эзэмших, орчны бүс болон нийт талбайг хариуцан хамгаалах, нөхөн сэргээх, зүй зохистой ашиглах чиглэлээр ажиллаж байна. Нөхөрлөлүүдийг чадваржуулах, бэхжүүлэх, ойг нөхөн сэргээж, хамгаалах ажлыг сайжруулах тал дээр анхаарал тавьж, ойг нөхөн сэргээх ойжуулах ажлын хүрээнд хувийн хөрөнгө оруулалтаар 7 аж ахуйн нэгж, 15 нөхөрлөл 18 га талбайд ойжуулалт хийсэн. Ойжуулалтын ажилд нийт 200 гаруй хүн оролцсон. Ойжуулалтын зардалд аж ахуйн нэгж, нөхөрлөлийн хөрөнгө 12.510.000 төгрөг зарцуулсан байна. | Бүрэн хэрэгжсэн<br>100% |  |
| 22.  | 35. | <b>Журам, жагсаалт шинэчлэн болон шинээр батлах тухай 2013.03.22 дугаар 106</b>  | Түймэрийн аюултай үеүүдэд түймэрээс урьдчилан сэргийлж нөхөрлөл, ААН, иргэдэд 4 удаа сургалт зохион байгуулсан. Сургалтанд нөхөрлөл,   | Бүрэн хэрэгжсэн<br>100% |  |

|     |     |  |   |                         |  |
|-----|-----|--|---|-------------------------|--|
|     |     | 2. Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, унтраахад шаардлагатай техник, багаж хэрэгслийг худалдан авахад шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын болон орон нутгийн төсөвт тусгаж байхыг ....аймаг нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.  | ААНэгжийн давхардсан тоогоор 300 орчим иргэн хамрагдсан. Мөн багийн ИНХурлуудад мэдээлэл хийж ойн түймэрээс урьдчилан сэргийлэх, асаасан гал, нурам, цогоо бүрэн унтрааж байх санамж бичиг, сэрэмжлүүлэгийг 300 ширхэг хийж иргэдэд тараасан. Байгаль хамгаалах нөхөрлөлүүдээс түймэр гаргахгүй байх баталгаа гаргуулж, эргүүл, хяналтын ажлыг сайжруулах үүрэг даалгавар өгч хамтран ажиллаж байна. Үүний үр дүнд 2019 онд ой хээрийн түймэр гаргаагүй.  |                         |  |
| 23. | 36. | <b>Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай</b><br><b>2014.09.18 дугаар 307</b><br>1. Ойгоос хэрэглээний мод бэлтгэж ашигласны төлбөрийн хэмжээг 1 дүгээр, Ойгоос түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн хэмжээг 2 дугаар, Иргэн, аж ахуйн нэгж байгууллага ойн арчилгаа, цэвэрлэгээний аргаар түлшний мод бэлтгэж ашигласны төлбөрийг хөнгөлөх хувь, хэмжээг 3 дугаар хавсралт ёсоор тогтоосугай.<br>2. Тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбоотой зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд С.Оюун, Сангийн сайд Ч.Улаан, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт даалгасугай. | Ойн нөөцийг хамгаалах, зүй зохистой ашиглуулах зорилгоор сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн “2019 оны хэрэглээний болон түлшний модны хуваарь батлах тухай” 2019 оны 01 дугаар сарын 08-ны өдрийн 1 дугаар тогтоол гарч хэрэгжүүлэн, сумын хэмжээнд 6 ойн мэргэжлийн байгууллага, Бат-Өлзий сумын 13 нөхөрлөлтэй гэрээ байгуулж, Сумын нийт дүнгээр 129 га талбайд хэрэглээний мод 3434 м3, түлшний мод 13246 м3 нийт 16680 м3 мод бэлтгэж, төсвийн орлогот 90.0 сая төгрөг төвлөрүүлэхээс 2019 оны 12 дугаар сарын 12-ны байдлаар 80.1 сая төгрөг төвлөрүүлсэн. | Бүрэн хэрэгжсэн<br>100% |  |
| 24. | 37. | <b>Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай /2016-2030/</b><br><b>2016.01.11 дугаар 35</b><br>2. Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд, хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг улс, орон нутгийн төсөвт тусган, олон улсын байгууллага, хандивлагч орон, хувийн хэвшлийн хөрөнгө оруулагчдыг татан оролцуулах замаар  | Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 2019 оныг “Тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх жил” болгон зарласантай холбогдуулан суманд жилийн ажлын нээлт хийж, зохион байгуулах ажлын хэсгийг томилж, жилийн ажлын төлөвлөгөө гарган хэрэгжилтийг зохион байгуулан ажилласан. 2019 оны 5-р сарын 30-ны байдлаар хаврын мод тарих арга хэмжээнд нийт 9 аж ахуйн нэгж, байгууллага, 214 иргэн оролцож 525 ширхэг мод, 5890 ширхэг бут сөөг   | Бүрэн хэрэгжсэн<br>100% |  |

|     |     |   |   |                         |  |
|-----|-----|---|---|-------------------------|--|
|     |     | санхүүжүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.  | буюу нийт 6415 ширхэг мод бут тарьсан. Мод тарих ажилд 16562500 төгрөгний хөрөнгө оруулалт хийгдсэн.  |                         |  |
| 25. | 38. | <b>Бугын эвэр түүж бэлтгэхийг түр хугацаагаар хориглох тухай</b><br><b>2018.04.20 дугаар 97</b><br>2.Энэхүү тушаалын хэрэгжилтийг хангаж, орон нутагт холбогдох арга хэмжээ авч ажиллахыг бүх шатны Засаг дарга нар, Аймаг нийслэлийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга, Тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны дарга, Сав газрын захиргааны дарга, Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газар /Г.Нямдаваа/, Тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газар /Ч.Батсансар/-т тус тус даалгасугай. | Ой, хээрийн түймэр, байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор ой, ойт хээрийн бүсэд байгалийн жамаар унасан бугын ясан эвэр түүх үйл ажиллагааг хориглсон тухай мэдээллийг иргэд, олон нийтэд мэдээлэл өгсөн. Сурталчилгаанд 200 гаруй иргэн хамрагдсан. Бугын эвэр түүж бэлтгэсэн зөрчил илрээгүй.   | Бүрэн хэрэгжсэн<br>100% |  |
| 26. | 39. | <b>Аялал жуулчлалын гол чиглэл батлах тухай</b><br><b>2018.06.13 дугаар 171</b><br>3.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан аймаг, нийслэлийн аялал жуулчлалын чиглэлүүдийг аялал жуулчлалын гол чиглэлтэй нийцүүлэн баталж, аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, дэд бүтцийн хөгжлийг хангаж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.  | Бат-Өлзий сумын Аялал жуулчлалын дэд хороог Засаг даргын орлогчоор ахлуулсан нийт 7 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулж, үйл ажиллагааны төлөвлөгөө гарган, хэрэгжүүлж ажилласан.<br>Өвөрхангай аймгийн аялал жуулчлалын маршрутыг брэнд бүтээгдэхүүн болгон хөгжүүлэх зорилгоор байгалийн аяллын төрлөөр Найман нуур, Улаан цутгалан, Төвхөн хийд чиглэлийн маршруттай болсон. 2019 онд 6 чиглэлийн аялалын маршрутын саналыг аймгийн БОАЖГазарт хүргүүлж, аялал жуулчлалын гол чиглэлд баталгаажуулсан. | Бүрэн хэрэгжсэн<br>100% |  |
| 27. | 40. | <b>Нэг удаагийн нийлэг хальсан уутыг хориглох тухай</b><br><b>2018.06.20 дугаар189</b><br>3. Энэ тогтоолын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээг олон нийтэд мэдээлэх, сурталчлан таниулах ажлыг зохион байгуулж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Хүнс,   | Энэхүү шийдвэрийг олон нийтэд хүргэх, сурталчилах ажлыг эхлүүлж, олон нийтийн сүлжээгээр мэдээлэл түгээж, дэлгүүр, худалдааны газруудаар зөвлөмж тарааж, хэрэгжүүлэн ажилласан. Засаг даргын Тамгын газрын эмэгтэй албан хаагчид Даавуун уут захиалгаар хийлгэж, олон нийтэд даавуун уут хэрэглэхийг уриалсан арга хэмжээг амжилттай зохион байгуулсан. Энэхүү арга хэмжээнд 400 гаруй иргэн мэдээлэл авч,  | Хэрэгжих шатанд<br>70%  |  |

|                                   |     |  |  |                         |  |
|-----------------------------------|-----|--|--|-------------------------|--|
|                                   |     | хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Б.Батзориг, аймаг, нийслэлийн Засаг дарга нар, Гаалийн ерөнхий газрын дарга Б.Асралт, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Н.Цагаанхүү нарт тус тус үүрэг болгосугай.  | даавуун уутны хэрэглээг сурталчилахад нэгдсэн. Даавуун уутны хэрэглээг иргэдэд хэвшүүлэхээр зорин ажиллаж байна.   |                         |  |
| 28.                               | 41. | Журам батлах тухай<br>2018.12.26 дугаар 391<br>1. “Зөвшөөрсөн хэмжээнээс илүү ашигласан усны төлбөр тооцох журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.<br>2. Энэ журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбатад, төлбөрийн орлогыг төсөвт төвлөрүүлэх арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай. | Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн хэмжээ тогтоосон шийдвэрийг мөрдөн ажиллаж, иргэн, аж ахуйн нэгжүүдэд сурталчилан 2019 онд ус ашигласны төлбөрт 12 баазаас нийт 680.0 мянган төгрөг орон нутгийн төсвийн орлогт төвлөрүүлж, 106 хувиар төлөвлөгөөг биелүүлсэн.   | Бүрэн хэрэгжсэн<br>100% |  |
| <b>3.3 Сайдын албан даалгавар</b> |     |  |  |                         |  |
| 29.                               | 42. | <b>Хууль бус мод бэлтгэлээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай 2015.01.25 дугаар 01</b><br>Хоёр. Сум, дүүргийн Засаг дарга нарт, аймгуудын Байгаль орчин, аялал жуулчлалын газруудад:<br>1. Хууль бус мод бэлтгэлтэй тэмцэх ажлыг эрчимжүүлж, хяналт, шалгалтын ажлыг тогтмол зохион байгуулах.  | Хууль бус мод бэлтгэлийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд хяналт, шалгалт 6 удаа зохион байгуулж, 26 зөрчил, 10 гэмт хэрэг илэрүүлж, холбогдох хууль журмын дагуу шийдвэрлэж байна. Сумын нутаг дэвсгэрт үйлдэгдэн гарч байгаа хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох иргэдийн хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор сумын ГХУСАЗСЗөвлөл, ЗДТГазар, Сум дундын ой анги, Цагдаагийн хэсгээс санаачлан 2019 оны 10 дугаар сарын 25-нд Соёлын төвд сургалт, өдөрлөгт зохион байгуулав. Энэхүү өдөрлөгт Өвөрхангай аймгийн Цагдаагийн газар, Хархорин сум дахь Цагдаагийн хэлтэс, Хархорин сум дахь Прокурорын газар, ОХБЦГазрын хамгаалалтын захиргаа, БОАЖГазар, Мэргэжлийн хяналтын газар оролцож, иргэдэд хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хуулийн сургалт, сурталчилгаа, зөвлөгөө мэдээллийг шуурхай өгч | Бүрэн хэрэгжсэн<br>100% |  |

|     |   |  |  |  |  |
|-----|---|--|--|--|--|
|     |   |  | ажиллаа. Сургалт, зөвлөгөөнд 400 гаруй иргэн хамрагдлаа. |  |  |
| 43. | 2. Сумын төвүүдэд мод, модон материалын төвлөрсөн захыг нээж, ажиллуулах, модны захыг бичлэг хийх боломжтой камераар тоноглож, өөр аймаг, сум руу тээвэрлэгдэж байгаа мод, модон материалыг зөвхөн энэ модны захаас гаргадаг нөхцөлийг бүрдүүлж ажиллах, ингэснээр мод, модон материалын гарал үүслийн гэрчилгээг нэг цэгээс олгох үйлчилгээг нэвтрүүлэх. | Модны захын эзэнтэй экологийн хариуцлагын гэрээ байгуулж, мод, модон материал боловсруулах цэгүүдийг камержуулсан. Модны зах дээр бүх нөхөрлөлүүдийн бэлтгэсэн хэрэглээ болон түлээний модыг төвлөрүүлж гарал үүслийн гэрчилгээг олгож байна. Нийт 913 ширхэг мод, модон материал тээвэрлэх гарал үүслийн гэрчилгээнд хяналт тавьж ажилласан. Зохих зөвшөөрөлгүй газарт хөрөө рам ажиллуулсан 1 ойн мэргэжлийн байгууллагын үйл ажиллагааг Прокурорын тогтоолоор зогсоосон.  | Бүрэн хэрэгжсэн 100%                                     |  |  |
| 44. | 3. Хууль бус мод бэлтгэлтэй тэмцэх чиглэлээр сайн дурын бүлэг байгуулж ажиллуулах асуудлыг дэмжих, хууль бус мод бэлтгэлтэй тэмцэх ажилд иргэн, нөхөрлөл, ТББ-ын оролцоог нэмэгдүүлэх   | Бат-Өлзий сумын Ойн анги, Байгаль орчны хяналтын улсын байцаагч, Байгаль хамгаалагч нар “Бат-Өлзий орчны бүсийн ойн нөхөрлөлүүд” ТББайгууллагатай хамтран хяналт шалгалтын ажлыг хамтран зохион байгуулж, оролцоог нэмэгдүүлж байна. Ойн мэргэжлийн байгууллага, 18 нөхөрлөлийн ахлагч нартай Хууль бус мод бэлтгэх зөрчлийг бууруулах чиглэлээр баталгаа гаргуулан авсан.   | Бүрэн хэрэгжсэн 100%                                     |  |  |
| 45. | 4. Ойн санг нөхөрлөл, ААН, байгууллагад гэрээгээр эзэмшүүлэх талбайн хэмжээг нэмэгдүүлэх, ойн санг гэрээгээр эзэмшиж байгаа нөхөрлөл, ААН, байгууллагын ойн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах.   | Ойн сангийн 40 хувийг 27 нөхөрлөл, ААН, байгууллагад гэрээгээр эзэмшүүлж, ойн санг гэрээгээр эзэмшиж байгаа нөхөрлөл, ААН, байгууллагуудын төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавин тайланг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар 2 удаа хэлэлцүүлэн, үнэлэлт, дүгнэлт өгсөн. Ойн санг гэрээгээр эзэмших, орчны бүс болон нийт талбайг хариуцан хамгаалах, нөхөн сэргээх, зүй зохистой ашиглах чиглэлээр ажиллаж, Нөхөрлөлүүдийг чадваржуулах, бэхжүүлэх, ойг нөхөн сэргээж, хамгаалах ажлыг сайжруулах тал дээр анхаарал тавьж, ойг нөхөн сэргээх ойжуулах ажлын үр дүнг сайжируулах, мэргэжил арга зүйн зөвлөгөөг өдөр тутам өгч ажиллаж байна. | Бүрэн хэрэгжсэн 100%                                     |  |  |



|  |     |  |  |                         |  |
|--|-----|--|--|-------------------------|--|
|  | 46. | 5. Ерөнхийлөгчийн 2014 оны “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 48 дугаар Зарлигийг сурталчлах, хэрэгжүүлэх ажлыг ойн мэргэжлийн байгууллага, төрийн байгууллага, нөхөрлөл, иргэдтэй хамтарч зохион байгуулан мэдээллийг ил тод болгох арга хэмжээ авах.   | Ерөнхийлөгчийн 2014 оны “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 48 дугаар Зарлигийг сурталчлах, хэрэгжүүлэх ажлыг 6 ойн мэргэжлийн байгууллага, 18 нөхөрлөлтэй хамтран хэлэлцүүлэг зохион байгуулж, хэлэлцүүлэгийн үр дүнд хууль бус мод бэлтгэлтэй эрчимтэй тэмцэх баталгаа гаргуулсан.  | Бүрэн хэрэгжсэн<br>100% |  |
|  | 47. | 6. ААН, байгууллагын бэлтгэх болон бэлтгэсэн модны хэмжээг ил тод болгох.  | Мод бэлтгэлийн мэдээллийг ил тод болгон сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж, мэдээллийн самбар, БИНХурлуудаар иргэдэд нээлттэй мэдээлдэг.   | Бүрэн хэрэгжсэн<br>100% |  |
|  | 48. | 7. Мод бэлтгэсэн ААН, нөхөрлөлийн өөрийн хөрөнгөөр ойжуулалт хийсэн байдлыг шалгах, хийгээгүй тохиолдолд нөхөн тариулах, шаардлагатай бол мэргэжлийн байгууллагын эрхийг цуцлах арга хэмжээ авах.  | Суманд 27 нөхөрлөл ойн санг гэрээгээр эзэмших, орчны бүс болон нийт талбайг хариуцан хамгаалах, нөхөн сэргээх, зүй зохистой ашиглах чиглэлээр ажиллаж байна. Нөхөрлөлүүдийг чадваржуулах, бэхжүүлэх, ойг нөхөн сэргээж, хамгаалах ажлыг сайжруулах тал дээр анхаарал тавьж, ойг нөхөн сэргээх ойжуулах ажлын хүрээнд хувийн хөрөнгө оруулалтаар 7 аж ахуйн нэгж, 15 нөхөрлөл 18 га талбайд ойжуулалт хийсэн. Ойжуулалтын ажилд нийт 200 гаруй хүн оролцсон. Ойжуулалтын зардалд аж ахуйн нэгж, ойн нөхөрлөл өөрийн хөрөнгө 12.510.000 төгрөг зарцуулсан байна. | Бүрэн хэрэгжсэн<br>100% |  |
| <b>Дундаж үнэлгээ</b>                          |     |  |  | <b>98,3%</b>            |  |
| <b>Дөрөв. Сангийн сайд</b>                     |     |  |  |                         |  |
| <b>4.1 Монгол Улсын Засгийн газрын тогтоол</b> |     |  |  |                         |  |
| 30.  | 49. | <b>Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай. 2009.04.01 дугаар 93</b><br>1.Тендерийн урилга, үр дүнг Засгийн газрын худалдан авах ажиллагааны цахим сүлжээнд /www.tender.gov.mn/ цаг хугацаанд нь бүрэн тавьж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан үндэслэлийг нээлттэй, ил тод мэдээлж байх | 2019 онд Худалдан авах ажиллагааны журмын дагуу дараах тендерүүдийг зарлаж, үүнд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Нийгмийн халамжийн сангаас зорилтот бүлгийн иргэдэд хүнсний эрхийн бичгээр үйлчлэх аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулах тендер /Нээлттэй/, 1-р Цэцэрлэгийн хүүхдийн хоолны материал нийлүүлэх тендер /нээлттэй/, 2-р Цэцэрлэгийн хүүхдийн хоолны материал нийлүүлэх тендер /харьцуулалтын аргаар/, ЭМТөвийн хэвтэн эмчлүүлэгчдийн хоолны материал нийлүүлэх тендер /Харьцуулалтын арга/, ЭМТөвд шатах, тослох                                | Бүрэн хэрэгжсэн<br>100% |  |

|     |   |  |                      |  |
|-----|---|--|----------------------|--|
|     |   | материал нийлүүлэх тендер /харьцуулалт/, ЕБС-ийн дотуур байрны хүүхдийн хоол нийлүүлэх тендер /Нээлттэй/ зэрэг нийт 6 тендерийг зарлаж, зохион байгуулсан. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 7 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулсан. Тендерийн урилга болон зарыг өдөр тутмын сонинд /нээлттэй тендер/, <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> цахим хуудсанд болон ЗДТГ-ын <a href="http://Bat-Ulzii.ov.gov.mn">Bat-Ulzii.ov.gov.mn</a> сайтад ил тод мэдээлсэн.  |                      |  |
| 50. | 2. Захиалагч бүр жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, худалдан авах ажиллагаанд хийсэн аливаа хяналт, аудитын тайлан, дүгнэлт, иргэд болон байгууллагаас гаргасан гомдлын тоо, агуулга, шийдвэрлэсэн байдлын талаар байгууллагын самбарт нийтэлж, нийтэд ил тод хүргэж байх | Тухайн онд ОНХСангийн хөрөнгөөр хийгдэх ажлын жагсаалт, төлөвлөгөөг сумын ИТХурлын 2018 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 10/10 дугаар тогтоолоор батлуулсан. Төлөвлөсөн ажлын жагсаалтыг иргэдэд нээлттэй мэдээлж, Худалдан авах ажиллагааны <a href="http://tender.gov.mn">tender.gov.mn</a> цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулсан. 2018 онд Улсын болон орон нутгийн хөрөнгө, ОНХСангийн хөрөнгөөр хийгдсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, бичиг баримтын бүрдүүлэлтэд Аудитын газар хяналт, шалгалт хийж зөрчил, дутагдал гаргаагүй. Аудитын дүгнэлтийг сумын ИТХ-д тайлагнасан бөгөөд цахим хаяг, мэдээллийн самбарт мэдээлснээр иргэд тендер шалгаруулалтын үр дүнгийн гүйцэтгэлийн талаар мэдээлэлтэй болсон. Суманд анх удаа иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, ЗДТГазар, “Либерал эмэгтэйчүүдийн оюуны сан” ТББайгууллагын Өвөрхангай аймаг дахь салбартай хамтран 2019 оны 10 дугаар сарын 08-нд "2017, 2018 оны ОНХС-ийн хөрөнгө оруулалтын төсвийн зарцуулалт, гүйцэтгэлд төсвийн хяналтын сонсгол" зохион байгуулалаа. Нийтийн сонсгол нийт 48 иргэн оролцож, 2017, 2018 онд ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсвийн зарцуулалтын талаар санал, бодлоо илэрхийлж, бодитой мэдээлэлтэй болов. | Бүрэн хэрэгжсэн 100% |  |

|     |     |   |  |                      |  |
|-----|-----|---|--|----------------------|--|
|     | 51. | 5. Захилагч бүр төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлд засаан захиалагчийн эрх, үүргийг бүрэн хэрэгжүүлж ажиллан, бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай бүрт мөн хуулийн 49.2-т заасан баримт бичиг, материалыг бүрдүүлж, архивын нэгж болгон хадгалж байх  | Улс, орон нутгийн болон ОНХСангийн хөрөнгөөр 2018 онд хийгдсэн төсөл, арга хэмжээний тендерийн бичиг баримт, материалыг бүрэн бүрдүүлж, цэгцлэн үдэж, ЗДТГ-ын архивын нэгж болгон хадгалсан.   | Бүрэн хэрэгжсэн 100% |  |
| 31. | 52. | <b>Журам шинэчлэн батлах тухай /Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам/ 2016.01.11 дугаар 29</b><br>2. Журмыг хэрэгжүүлж ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит компани, төрийн өмчит үйлдвэрийн газар, хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани, улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага болон төрийн чиг үүргийг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч нарт үүрэг болгосугай. | Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд Сумын Төсвийн ерөнхийлөн захирагч-1, Төсвийн байгууллагууд – 7 /ИТХ, ЗДТГ, ЕБС, 1-р Цэцэрлэг, 2-р Цэцэрлэг, ЭМТөв, Соёлын төв/ цахим хуудсаар нийтэд мэдээлэн ажиллаж байна. Хуулийн дагуу нийтэд ил тод байх нийт 30 төрлийн мэдээллээс өөр өөрийн цахим хуудсанд тохирох мэдээллийг журмаар тогтоосон хугацаа, шаардлагын үнэн зөв оруулж, заалт бүр дээр анхааран журмыг хэрэгжүүлсэн.   | Бүрэн хэрэгжсэн 100% |  |
| 32. | 53. | <b>Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2016.01.04 дугаар 15</b><br>1. Дараах арга хэмжээ авч ажиллахыг төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосугай:<br>1.1. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллан, татварын нэгдсэн системд холбогдох;<br>1.2. бараа, ажил, үйлчилгээг худалдан авах болон борлуулах тухай бүрт төлбөрийн баримт хэрэглэж, үүнийг хэвшүүлэх;  | Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж, суманд үйл ажиллагаа явуулж буй 7 төсөвт байгууллага, 11 аж ахуйн нэгж, 22 дэлгүүр, үйлчилгээний газар татварын нэгдсэн системд холбогдож, төлбөрийн баримт хэвлэж байна. Нэмэгдсэн өртгийн албан татварын хуулийн сургалт, сурталчилгааг 5 удаа зохион байгуулж, 520 иргэн хамрагдаж, нэмэгдсэн өртгийн албан татварын хуулийн талаар мэдээлэлтэй болсон. Худалдаа үйлчилгээ эрхлэгч 5 хүнд Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийг хэрэгжүүлэх төлбөрийн баримт хэрэглэх тухай хугацаатай мэдэгдэл, шаардлагыг хүргүүлж ажилласан. | Хэрэгжих шатанд 70%  |  |

|  |     |  |   |                         |  |
|--|-----|--|---|-------------------------|--|
|  |     | 1.3. иргэд, хуулийн этгээдэд төлбөрийн баримт хэрэглэх үйл ажиллагааг хэвшүүлэх талаар нийтэд сурталчлан таниулах.   | “Татварын шинэчлэл-2” аян Бат-Өлзий суманд 2019 оны 11 дүгээр сарын 04-нд аймгийн Татварын хэлтэс, сумын татварын улсын байцаагч нар хамтран иргэдэд Татварын шинэчилсэн хуулиар сургалт зохион байгуулж, хуулийн хэрэгжилтийн байдалтай танилцаж, зөвлөгөө өгөв. Сургалт, мэдээлэлд 100 гаруй иргэн хамрагдсан.  |                         |  |
| <b>4.2 Сайдын тушаал</b>                       |     |  |   |                         |  |
| 33.  | 54. | Журам шинэчлэн батлах тухай<br>2018.12.31 дугаар 318<br>1. “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталж, 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдүүлсүгэй.<br>2. Шинэчлэн баталсан журмыг мөрдөж ажиллахыг холбогдох төсвийн захирагч нарт үүрэг болгосугай.  | Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын шинэчилсэн журмыг 2019 оны 1 дүгээр сарын 1-ны өдрөөс эхлэн мөрдөж, сумын Засаг даргын шийдвэрээр Засаг даргын нөөц сангаас 9052500 төгрөгийн зардлыг Засаг даргын зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн зарцуулсан.   | Бүрэн хэрэгжсэн<br>100% |  |
| Дундаж үнэлгээ                                 |     |  |   | 95%                     |  |
| <b>Тав. Хууль зүйн, дотоод хэргийн сайд</b>    |     |  |   |                         |  |
| <b>5.1 Ерөнхийлөгчийн зарлиг</b>               |     |  |   |                         |  |
| 34.  | 55. | <b>Монгол Улсын Төрийн тугийг хүндэтгэх тухай 2017.06.16 Дугаар 136</b><br>1. Монгол Улсын төрийн хүндэтгэлийн бэлгэдэл Монголын нэгдсэн тулгар төрийн уламжлалт Их цагаан тугийг гүнээ дээдлэн хүндэтгэж байхыг иргэдэд уриалсугай.<br>2. Есөн хөлт Их цагаан тугийг дууриалган үйлдсэнийг төр, олон нийтийн аливаа үйл ажиллагаанд ашиглахгүй байхыг төрийн захиргаа, нутгийн өөрөө удирдах болон холбогдох бусад байгууллагад даалгасугай.<br>3. Төрийн бэлгэ тэмдгийн тухай хууль болон холбогдох бусад журмыг дагаж мөрдөх, биелэлтэд хяналт тавихыг бүх шатны Засаг даргад үүрэг болгосугай. | Монгол Улсын төрийн хүндэтгэлийн бэлгэдэл Монголын нэгдсэн тулгар төрийн уламжлалт Их цагаан тугийг гүнээ дээдлэн хүндэтгэж байх талаар албан газар, аж ахуйн нэгж, иргэдэд хандан уриалга гаргасан. Төрийн байгууллагууд төрийн тугийг хүндлэн Есөн хөлт Их цагаан тугийг дууриалган үйлдсэнийг төр, олон нийтийн аливаа үйл ажиллагаанд ашиглахыг зогсоож, төрийн бэлгэ тэмдгийн тухай хууль болон холбогдох бусад журмыг дагаж мөрдөн, биелэлтэд хяналт тавин ажиллаж байна. Бат-Өлзий сумынхаа Есөн хөлт цагаан тугийг ЗДТГазрын “Хүндэтгэлийн танхим”-д байршуулсан. | Бүрэн хэрэгжсэн<br>100% |  |
| <b>5.2 Монгол Улсын Засгийн газрын тогтоол</b> |     |  |   |                         |  |

|     |     |   |   |                      |  |
|-----|-----|---|---|----------------------|--|
| 35. | 56. | <p><b>Байгууллага, иргэдээс ирүүлсэн албан бичиг өргөдөл гомдлын шийдвэрлэлтийг шуурхай болгохтой холбогдсон зарим арга хэмжээний тухай</b><br/> <b>2007.05.03 дугаар08</b><br/> 1.Байгууллага иргэдээс ирүүлсэн болон дээд шатны байгууллагаас шийдвэрлүүлэхээр хүргүүлсэн албан бичиг хүсэлтийг тухайн асуудлыг хариуцсан ажилтанд шуурхай хүргэж хууль тогтоомжинд заасан хугацаанд хариу өгч байх</p> | <p>Байгууллага, иргэдээс болон дээд шатны байгууллагаас шийдвэрлүүлэхээр ирүүлсэн албан бичгийг ЗДТГ-ын архив, бичиг хэргийн эрхлэгч хариуцан бүртгэж тайлант хугацаанд 200 албан бичгийг бүртгэн, холбогдох ажилтанд шуурхай хүргэж, хариутай 72 албан бичигт хяналт тавьж 72 албан бичиг хугацаандаа явсан. ЗДТГаараас өөр байгууллага, албан тушаалтанд нийт 357 албан бичиг бүртгэн шилжүүлсэн.</p>   | Хэрэгжих шатанд 70%  |  |
| 36. | 57. | <p><b>Сургалт, семинарын зохион байгуулалтыг сайжруулах тухай</b><br/> <b>2008.11.12 дугаар 32</b><br/> 3.а Сургалт, семинарын нэгдсэн хуваарийн биелэлтэд байнгын хяналт тавьж, төлөвлөгдсөн арга хэмжээнд ажилтнуудаа оролцуулан, тэдгээрийн томилолтын тайлан, үр дүнг тогтмол дүгнэж байх.</p>  | <p>Сургалт, семинарын нэгдсэн хуваарийн биелэлтэд байнгын хяналт тавьж, байгууллагын менежерүүд сургалтын үр дүнг тооцож хэвшсэн. 2019 онд давхардсан тоогоор 140 төрийн албан хаагч 1-15 хоногийн хугацаатай сургалт, семинарт хамрагдаж мэргэжил, ур чадвараа дээшлүүлж байна. Цаашид сургалт, семинар зохион байгуулж буй байгууллагууд чанартай, үр дүнтэй, суманд хэрэгтэй сургалтуудыг сиситемтэйгээр явуулж байх нь зүйтэй.</p>  | Бүрэн хэрэгжсэн 100% |  |
| 37. | 58. | <p><b>Аймаг, нийслэлийн Засаг дарга нарт</b><br/> <b>2010.04.07 дугаар 21</b><br/> 4.1.Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг байгууллагынхаа онцлогт тохируулан судалгааны үндсэн дээр бодитой төлөвлөж, тэдгээрийг хэрэгжүүлэх талаар удирдлагын манлайллыг сайжруулах</p>   | <p>Авлигатай тэмцэх, авлигын эсрэг сумын нэгдсэн төлөвлөгөөг боловсруулан сумын Засаг даргаар батлуулсан. Авлигын эсрэг хуулийг төрийн албан хаагчдад сурталчлан, Нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангуулж, авлигад өртөх эрсдэл бүхий ажил, албан тушаалын жагсаалт, судалгааг гарган хяналт тавин ажиллаж, байгууллагуудын дотоод журамд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр заалт оруулж батлан мөрдүүлсэн.</p> | Бүрэн хэрэгжсэн 100% |  |
|     | 59. | <p>4.2.Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх, түүнд хяналт тавих, тайлагнах асуудлыг эрчимжүүлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авах</p>   | <p>Тухайн онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж, төрийн албан хаагчдаас авлигатай холбоотой ямар нэгэн гэмт хэрэгт холбогдоогүй. Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчилан багийн иргэдийн нийтийн хурлуудаар 700 гаруй иргэнд мэдээлэл өгсөн. Авлигын эсрэг төлөвлөгөөний</p>  | Бүрэн хэрэгжсэн      |  |

|     |     |  |   |                         |  |
|-----|-----|--|---|-------------------------|--|
|     |     |  | биелэлтийг аймгийн ЗДТГ-ын ХЭЗХэлтэст хугацаанд нь тайлагнаж хэвшсэн.   | 100%                    |  |
| 38. | 60. | <b>Цагдаагийн байгууллагын талаар авах зарим арга хэмжээний тухай 2011,05,11 Дугаар 153</b><br>5. Тухайн нутаг дэвсгэрийн Цагдаагийн байгууллагын хэвийн ажиллах нөхцлийг бүрдүүлэх цагдаагийн абан хаагчдын ажиллаж амьдрах нөхцлийг дээшлүүлэх талаар тодорхой арга хэмжээ авч ажиллахыг аймаг нийслэлийн ЗД нарт үүрэг болгосугай   | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, орон байр, эд хөрөнгийн хулгай илрүүлэх, таслан зогсоох, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор жил бүр шат дараатай бодит ажлуудыг хамтран зохион байгуулж хэвшсэн. Тайлант хугацаанд Цагдаагийн хэсгийн автомашины засвар, үйлчилгээний зардалд сумын Засаг даргын нөөц сангаас 2,0 сая төгрөгийг шийдвэрлэж, цагдаагийн байгууллагын хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлж өгсөн.  | Бүрэн хэрэгжсэн<br>100% |  |
| 39. | 61. | <b>Журам батлах тухай /тамхины үйлдвэрлэл, импорт, худалдаа, үйлчилгээнд хяналт тавих журам/ 2012.05.25 дугаар 191</b><br>4.Тамхины үйлдвэрлэл, импорт, худалдаа, үйлчилгээнд хяналт тавих журмыг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч, шаардагдах зардлыг батлагдсан төсвийн хүрээнд тусган шийдвэрлэж байхыг холбогдох яам, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай | Сумын нутаг дэвсгэрт тамхи худалдах тусгай зөвшөөрөлтэй дэлгүүр болон бусад цэгүүдэд шалгалт хийж, ЕБСургуулийн хичээлийн байр, дотуур байрнаас 500 метрт байрлах дэлгүүрүүдэд тэмдэглэгээ хийж, тамхи худалдах тусгай зөвшөөрөлтэй дэлгүүрүүдийн тусгай зөвшөөрлийн хугацааг шалгаж, 28 дэлгүүрийн судалгааг шинэчилсэн. Журамд заасан шалгуурыг дэлгүүрийн эздэд мөрдүүлж, үүрэг чиглэл өгч ажилласан. 2019 онд сумын Засаг даргын захирамжаар 28 дэлгүүрийн тамхи худалдах тусгай зөвшөөрлийн хугацааг сунгаж, шинээр 3 дэлгүүр олгосон. | Бүрэн хэрэгжсэн<br>100% |  |
| 40. | 62. | <b>Журам батлах тухай. /цахим тоглоомын газрын үйл ажиллагааг зохицуулах тухай/ 2013.12.14 дугаар 410</b><br>2.Энэхүү журмын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хууль зүйн сайд ..., Мэдээллийн технолги, шуудан, харицаа холбооны газар ..-т, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай   | Сумын ГХУСАЗСЗөвлөлийн томилсон ажлын хэсгийн бүрэлдэхүүн суманд ажиллаж байгаа цахим тоглоомын газарт Засгийн газрын 2013 оны 410 дугаар тогтоолоор баталсан “Цахим тоглоомын ажиллах журам”-ын хэрэгжилтийг шалган, хугацаатай мэдэгдэл өгч, үйл ажиллагааг зогсоосон.  | Бүрэн хэрэгжсэн<br>100% |  |
| 41. | 63. | <b>Журам батлах тухай 2017.07.04 Дугаар 195</b>  | Сумын Засаг даргын захирамжаар Орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүн, үнэлэх, худалдан борлуулах, устгалын 3 комиссыг шинэчлэн байгуулж, үйл   |                         |  |

|   |     |   |  |                        |  |
|---|-----|---|--|------------------------|--|
|   |     | 2. Албадлагын арга хэмжээ авсантай холбоотой хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслээс хохирол нөхөн төлүүлэх тусгай дансыг Сангийн яамнаас тогтоосон журмын дагуу нээж, ашиглах арга хэмжээ авахыг эрх бүхий байгууллагын дарга нарт даалгасугай.  | ажиллагааг жигдрүүлсэн. Хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслээс хохирол нөхөн төлүүлэх тусгай дансыг Сангийн яамнаас тогтоосон журмын дагуу төсвийн орлогын дансанд төвлөрүүлж ажилладаг.  | Бүрэн хэрэгжсэн 100%   |  |
| <b>Дундаж үнэлгээ</b>                             |     |   |  | 96,6%                  |  |
| <b>Зургаа. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд</b> |     |   |  |                        |  |
| <b>6.1 Монгол Улсын Их Хурлын тогтоол</b>         |     |   |  |                        |  |
| 42.   | 64. | <b>Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар авах зарим арга хэмжээний тухай. 2013.02.07 дугаар 20</b><br>6/аж ахуйн нэгж, байгууллагад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны ажилтны тоог тухайн аж ахуйн нэгж, байгууллагын ажилтны тоо, ажлын байран дахь эрсдэлийн түвшнээс хамааруулан тогтоох, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл болон мэргэжлийн холбоотой хамтран ажиллах чиглэлээр холбогдох арга хэмжээг авах; | 2019 оны 5 дугаар сарын 3-нд сумын ЗДТГазар, аймгийн МХГазрын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хяналтын улсын байцаагчтай хамтран хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавин, албан байгууллага, аж ахуйн нэгжийн удирдлагууд, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн гишүүдэд сургалт зохион байгуулсан. Сургалтанд 15 хүн хамрагдсан. Суманд үйл ажиллагаа явуулж буй 5 хөрөө рам ажиллуулдаг газарт Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр МХГазрын улсын байцаагч нарын хамтарсан хяналт, шалгалт хийж, хөдөлмөрийн аюулгүй байдлын зааварчилгаа өгсөн. | Бүрэн хэрэгжсэн 100%   |  |
| <b>6.2 Монгол Улсын Засгийн газрын тогтоол</b>    |     |   |  |                        |  |
| 43.   | 65. | <b>Үндэсний мэргэжилтэй ажилтан бэлтгэх талаар авах зарим арга хэмжээний тухай. 2010.08.18 дугаар 212</b><br>4. МСҮТөвд суралцах ажилгүй иргэдийн квотыг үндэслэн ажилгүй иргэдээ сургалтад хамруулах арга хэмжээг сайтар зохион байгуулах, энэхүү сургалтад хамрагдахад нь иргэдэд дэмжлэг, туслалцаа үзүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасан.   | Мэргэжлийн сургалтанд хамрагдах зар мэдээллийг гаргаж сургалтанд явах хүсэлтэй иргэдийг Хөдөлмөр, нийгмийн халамжийн мэргэжилтэн бүртгэж заавар зөвлөгөөг өгч байна. 2019 оны 5 дугаар сарын 27-29-ны өдрүүдэд “Аж ахуй эрхлэлт болон хөдөлмөр эрхлэх ур чадвар олгох” 26 цагийн сургалтанд Хөгжлийн бэрхшээлтэй болон ХБИргэнийг асран хамгаалагч нийт 20 иргэнийг хамруулсан. Сургалтанд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй 1 иргэнд ХЭДСангаас 2.5 сая төгрөгийн зээл олгож, үйл ажиллагааг дэмжсэн.   | Бүрэн хэрэгжсэн 100%   |  |
| 44.   | 66. | <b>Шалгуур үзүүлэлт батлах тухай 2012.01.18 дугаар 15</b><br>2.Шалгуур үзүүлэлтийн мэдээллийг жил бүрийн I улиралд багтаан мэдээллийн нэгдсэн санд  | Хүүхдийн эсэн мэнд амьдрах, хөгжих, хамгаалуулах, оролцох эрхийн 4 бүлгийн 38 шалгуур үзүүлэлтээр мэдээллийг нэгдсэн санд төвлөрүүлж, хүүхдийн эрхийн байдалд дүн шинжилгээ хийж, тайлан мэдээг  | Хэрэгжих шатандаа 100% |  |

|     |     |   |   |                           |  |
|-----|-----|---|---|---------------------------|--|
|     |     | төвлөрүүлж, харьцуулсан дүн шинжилгээ хийж ажиллахыг ЗГ-ын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай  | гаргасан. Сумын хэмжээнд 0-18 насны 3016 хүүхэд, 2019 онд 130 хүүхэд төрсөн. Хүнд хэлбэрийн хөдөлмөр эрхэлдэг буюу мал малладаг 8 хүүхэд бүртгэгдсэн. Дотуур байранд 146 хүүхэд амьдарч байгаа бөгөөд ЕБС-д 1612 суралцагч сургуульд хамрагдан нийт 54 бүлэг хичээллэж байна. Цэцэрлэгт 564 хүүхэд хүмүүжиж байгаа. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асаргааны тэтгэмж авдаг хүүхэд 35 хүүхэд, хүүхдийн оролцооны байгууллагын тоо 10, Хүүхэдтэй холбоотой гарсан шийдвэр 4, хүүхэдтэй холбоотой гэмт хэрэг гараагүй. Хүүхдийн эндэглэл гараагүй, дугуйлан секцэнд 1250 сурагч хамрагдаж байгаа бөгөөд үүнээс спортын секцэнд 520 гаруй сурагч хамрагдаж байна. Эдгээр зорилтуудыг хэрэгжүүлэх үүднээс 6 удаагийн сургалт, мэдээллийг хийж нийт 380 гаруй сурагч, 390 иргэн хамрагдсан. Багийн ИНХурлуудаар 380 иргэнд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн гарын авлага тарааж ажилласан. |                           |  |
| 45. | 67. | <b>Конвенцийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай.</b><br><b>2013.08.02 дугаар 281</b><br>2.Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хөгжлийн бэрхшээлтэй иргэд, иргэний нийгмийн оролцоотойгоор салбар, орон нутгийнхаа түвшинд хэрэгжүүлэх ажлын нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулан баталж хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай. | Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан Хөгжлийн бэрхшээлтэй байнгын асаргаанд байдаг хүүхдүүдэд сумын Нийгмийн ажилтан, хүнсний эрхийн бичгээр хүнс олгодог 3 дэлгүүртэй хамтран 35 хүүхдийг хүлээн авч, бэлэг өгч баярлуулсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн байнгын асаргаа шаардлагатай 35 хүүхдийг Эрүүл мэндийн төвийн өдрийн үйлчилгээнд хамруулсан. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд хууль журмынхаа дагуу тэтгэвэр, тэтгэмжээ бүрэн авч байна.   | Хэрэгжих шатандаа<br>100% |  |
| 46. | 68. | <b>Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай</b><br><b>2016.05.02 дугаар 234</b><br>2. Монголын улаан загалмай нийгэмлэгээр Засгийн газар, нутгийн захиргааны байгууллагын зарим чиг үүргийг гүйцэтгүүлэх үйл ажиллагааг удирдан зохион байгуулах чиг үүрэг бүхий зөвлөлийг үндэсний болон орон нутгийн түвшинд байгуулан ажиллахыг Монгол Улсын Шадар сайд  | Бат-Өлзий сумын анхан шатны Улаанзагалмайн хороо 9 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдаж үйл ажиллагаа жигдэрсэн. ЕБСургуулийн 9а ангийн 26 сурагч Өсвөрийн Улаан загалмайд элсэж, зорилтод бүлгийн 3 өрхөд тусламж үзүүлсэн. 2019 онд 15 иргэн МУЗН-ийн гишүүнээр элсэж, 135000 төгрөгийн татварыг дансанд төвлөрүүлсэн. МУЗН-ийн гишүүд татвараа жил бүр төлж хэвшсэн. Сумын Улаан загалмайн анхан шатны  | Бүрэн хэрэгжсэн<br>100%   |  |



|     |     |  |   |                         |  |
|-----|-----|--|---|-------------------------|--|
|     |     | Ц.Оюунбаатар, аймаг, дүүргийн Засаг дарга нарт, зөвлөлийн ажиллах журмыг баталж мөрдүүлэхийг Монгол Улсын Шадар сайд Ц.Оюунбаатарт тус тус даалгасугай.<br>3. Хүмүүнлэгийн чиглэлээрх Засгийн газрын зарим чиг үүргийг Монголын улаан загалмай нийгэмлэг гүйцэтгэх болсонтой холбогдуулан тус нийгэмлэгт төсвөөс олгох санхүүжилтийг 2017 оноос эхлэн улсын болон орон нутгийн төсөвт тусгаж байхыг Монгол Улсын Шадар сайд Ц.Оюунбаатар, Сангийн сайд Б.Болор, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай. | хорооноос Донорын өдрийг тохиолдуулан хүндэт донор 5 иргэнд, Эрдмийн баярыг тохиолдуулан 3 сурагчид “Хүндэт өргөмжлөл”, мөнгөн шагналаар шагнаж урамшуулсан.<br>Улаан загалмайн анхан шатны хорооны 2019 оны 1 дүгээр тогтоолоор удирдах зөвлөлийн гишүүдийг шинэчлэн баталсан. |                         |  |
| 47. | 69. | <b>Насны хишиг олгох журам батлах тухай 2017.01.25 дугаар 31</b><br>2. Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан журмын дагуу ахмад настанд насны хишиг олгох ажлыг 2017 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн зохион байгуулж, хэрэгжилтэнд нь хяналт тавьж ажиллахыг ХНХ-ын сайд Н.Номтойбаярт үүрэг болгосугай.   | Насны хишгийн мөнгийг 2019 онд 65-69 насны 96 ахмад натанд 4800.0 мян.төг, 70-79 насны 89 ахмад настанд 7120.0 мян.төг, 80-89 насны 31 ахмад настанд 4650.0 мян.төг, 90-с дээш насны 5 ахмад настанд 1250.0 мян.төг, нийт 17820.0 мян.төгрөгийг бүрэн олгосон.                  | Бүрэн хэрэгжсэн<br>100% |  |
| 48. | 70. | Хурдан морины уралдааны талаар авах зарим арга хэмжээний тухай<br>2019.01.30 дугаар 57<br>1. Жил бүрийн 11 дүгээр сарын 1-ний өдрөөс 5 дугаар сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд хурдан морины уралдаан, сунгаа, үсэргээ зохион байгуулахыг хориглосугай.<br>3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд Ө.Энхтүвшин, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг, Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, бүх шатны Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.                                    | Бат-Өлзий сумын нутаг дэвсгэрт тогтоосон хугацаанд хурдан морины уралдаан, сунгаа, үсэргээ зохион байгуулаагүй болно. Энэхүү шийдвэрийг хэрэгжүүлж, холбогдох хүмүүст мэдэгдэл хүргүүлсэн.  | Бүрэн хэрэгжсэн<br>100% |  |
| 49. | 71. | <b>Төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай 2019.03.21 дугаар 111</b>  | 2019 онд 25-с дээш ажилтантай 3 байгууллагын судалгааг гаргаж, эдгээр байгууллагууд заасан квотод тулгуурлан хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг  | Бүрэн хэрэгжсэн<br>100% |  |

|     |     |  |   |                                 |  |
|-----|-----|--|---|---------------------------------|--|
|     |     | <p>2. Бүх шатны төсвийн байгууллага, төрийн буюу орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг тогтоосон хувь хэмжээгээр ажиллуулах, ажиллуулаагүй тохиолдолд зохих төлбөрийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлэх арга хэмжээ авч ажиллахыг төсвийн шууд захирагч нарт үүрэг болгосугай.</p>   | <p>ажиллуулж байна. Дээрх 3 байгууллагын хөгжлийн бэрхшээлтэй иргэний хяналтын карт нээж, материалуудыг баяжуулсан.</p>   |                                 |  |
| 50. | 72. | <p>2019-2020 оныг хүүхдийн хөгжил, хамгааллын жил болгон зарлах тухай<br/>2019.05.29 дугаар 210</p> <p>1. Хүүхдийн хөгжил, хамгааллын чиглэлээр хэрэгжүүлж байгаа олон талт ажлыг эрчимжүүлэх зорилгоор 2019-2020 оныг Хүүхдийн хөгжил, хамгааллын жил болгон зарласугай.</p> <p>2. Хүүхдийн хөгжил, хамгааллын жилийн хүрээнд хэрэгжүүлэх салбар дундын ажлын төлөвлөгөөг Хүүхдийн төлөө Үндэсний зөвлөлөөр батлуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзоригт, хүүхдийн хөгжлийг дэмжих, эрсдлээс урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгааллын үйлчилгээний хүртээмж, чанар, үр дүнг сайжруулахад анхаарч, салбар бүртээ дэд ажлын төлөвлөгөөг батлан, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Хүүхдийн төлөө Үндэсний зөвлөлийн гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.</p> | <p>Шийдвэрийг хяналтад авч, хүүхдийн хөгжлийг дэмжих, эрсдлээс урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгааллын үйлчилгээний хүртээмж, чанар, үр дүнг сайжруулахад анхаарч төлөвлөгөө гарган хэрэгжүүлсэн. Онцлох ажлуудаас дурдвал: Амьжиргааны түвшин доогуур, эрхэлсэн тодорхой ажилгүй, малгүй, хүнсний эрхийн бичигт хамрагддаггүй 1-12 насны 4 хүүхэдтэй гэр бүлд нь туслах зорилгоор “Хайраа түгээцгээе” сайн үйлсийн аян өрнүүлж 890 000 төгрөгийн дулаан хувцас, хоол хүнсний дэмжлэг үзүүлсэн. 8 настай цавьны эвэрхийтэй хүүхдийг аймаг БОЭТ-д шаардлагатай шинжилгээнд хамруулж 2019 оны 11 дүгээр сарын 15-нд эвэрхийний хагалгаанд орж одоо биеийн байдал сайжирч хичээл сургуульдаа явж байна.</p> <p>Дотуур байранд амьдарч байгаа 126 хүүхдийн дунд тэмцээн уралдаан, сургалт зохион байгуулж, судалгаа авч үр дүнг нь тооцсон. Хүүхдийн хоолны амт чанар, хүүхдийн аюулгүй байдал, хүүхдийн эрхийн талаар 2 удаагийн хяналт шалгалтыг ИТХ-аас томилсон 5 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг хяналт, шалгалтыг явуулж, зөвлөмж хүргүүлэн ажиллаж, зөрчлийг тухай бүрт нь арилгуулж ажилласан. Хүүхдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор дотуур байранд уншлагын танхимтай болсон. ГБХЗАХМэргэжилтэн, сургуулийн нийгмийн ажилтан хамтран 42 хүүхдэд сэтгэл зүйн анхан шатны зөвлөгөөг өгсөн. Хүүхэд хамгааллын хамтарсан баг нь он гарсаар 4 хүүхдийн</p> | <p>Бүрэн хэрэгжсэн<br/>100%</p> |  |

|  |  |  |  |
|--|--|--|--|
|  |  | <p>үрчлэлтэнд нөхцөл байдлын үнэлгээ хийж үрчлэгдсэн хүүхдүүдэд хяналт тавин ажиллаж, зорилтод өрхийн 30 өрхөд нөхцөл байдлын үнэлгээ хийж төлөвлөгөө гарган, тухайн өрхүүдэд кейс нээн ажиллаж байна. Хурдан морины уралдааны үеэр хүүхэд хамгааллын хамтарсан баг хяналт тавин ажиллаж хүүхдийн гэнэтийн ослын даатгалд хамрагдаагүй 12 хүүхэд, хамгаалах хувцас хэрэгслийг бүрэн өмсөөгүй 9 хүүхдүүдэд хяналт тавин ажиллаж зөрчлийг тухайн үед арилгуулсан. Өнгөрсөн жилийг бодвол уяачид болон эцэг эх, асран хамгаалагчид холбогдох ажилтнуудын шаардлагыг биелүүлж унаач хүүхдүүдийг гэнэтийн ослын даатгалд бүрэн хамруулж, хамгаалах хувцас хэрэгслийг бүрэн өмсгөж уралдааны замд гаргасан юм. Насанд хүрээгүй хүүхдүүд мотоцикль жолоодож мал хариулах, адууны эрэлд явах улмаар бэртэж гэмтэх үзэгдэл гарах магадлал маш өндөр байгаа учраас Цагдаагийн хэсэгтэй хамтран ажиллаж учирч болох эрсдлүүдийг танилцуулж, зөвлөмж зөвлөгөөг 15 хүүхдэд өгч, 29 эцэг, эхэд учирч болох эрсдлийн талаар мэдээлэл өгч ажиллаа. Мөн Хүүхдүүд үер усны аюулаас болгоомжилсон анхааруулга самбарыг өвтийн гол, улаан цутгалан, төвхөн, орхон гол, цагаан гол гэсэн 5 байршилд байршуулж, 68 иргэнд мэдээлэл өгсөн. Хүүхэд, гэр бүлийг чөлөөт цагаан зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор Орон нутгийн хөгжлийн сангийн 36.0 сая төгрөгийн санхүүжилтээр цэцэрлэгт хүрээлэнг тохижуулж, шинээр волейбол, сагсны талбай байгуулсан. СӨББ 1,2-т уламжлал ёс заншлын булан байгуулагдсанаар хүүхэд бүрт боловсрол олгох ажил тогтмолжсон. Мөн сумын хэмжээнд “Хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга”, Угийн бичгийн сургалтыг 15-34 насны залуучууд, залуу гэр бүлүүд, бусад насны иргэдийг дунд зохион байгуулж нийт 485 иргэнийг хамруулсан.</p> |  |
|--|--|--|--|

|  |     |   |   |                                 |  |
|--|-----|---|---|---------------------------------|--|
| 51.  | 73. | <p>Журам шинэчлэн батлах тухай<br/>2019.08.28 дугаар 338</p> <p>3. Малчин өрхийг малынхаа тоог бэлчээрийн даацад тохируулан бэлчээрийг зохистой ашиглаж байгаа байдал, малын чанарыг сайжруулж нэг малаас авах ашиг шим (мах, сүү, ноос, ноолуур)-ийг нэмэгдүүлсэн, малаа мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд бүрэн хамруулсан, эрүүл чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг, тэдний нийгэмд оруулж байгаа хувь нэмэр зэрэг шалгуур үзүүлэлтийг харгалзан орон нутагтаа шалгаруулан шагнан урамшуулж байхыг аймаг, сумын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.</p> | <p>Журамд заасан шалгуур үзүүлэлтийг хангасан 1 дүгээр багийн малчин өрх Л.Дашийг Улсын хошой аварга малчин өрх, 2 дугаар багийн малчин Д.Буянбадрахыг Улсын аварга малчин өрхөөр шалгаруулахаар бичиг баримтыг бүрдүүлж, холбогдох газарт уламжилсан.</p>  | <p>Бүрэн хэрэгжсэн<br/>100%</p> |  |
| Дундаж үнэлгээ                                 |     |   |   | 100%                            |  |
| <b>Долоо. Батлан хамгаалахын сайд</b>          |     |   |   |                                 |  |
| <b>7.1 Монгол Улсын Засгийн газрын тогтоол</b> |     |   |   |                                 |  |
| 52.  | 74. | <p><b>“Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний тоо бүртгэл хөтлөх, мөнгөн төлбөрийг төлөх, хураан авах, төлбөрийн орлогыг ашиглах журам” батлах тухай</b><br/><b>2016.04.18 дугаар 215</b></p> <p>2. Журмын хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Батлан хамгаалахын сайд Ц.Цолмон, Сангийн сайд Б.Болор, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.</p>  | <p>Дүйцүүлэх албанаас 2019 онд 5 цэрэг халж, 2018-2020 онд цэргийн дүйцүүлэх албанд 4 цэрэг алба хааж байна. Сумын бүтээн байгуулалт болох зам, даваа, гүүр засах, нийтийн хог цэвэрлэгээнд оролцох, Орхон бага сургуулийн барилгын ажил, Орхон голын гүүр барих ажлыг гүйцэтгэсэн. Мөн малчдад тусламжаар ирсэн 3000 боодол өвс, 20 тн малын тэжээлийг буулгаж нийт 60-78 цагийн ажил хийлгэсэн. Цэргийн албыг мөнгөн төлбөрөөр орлуулан хаасан иргэн байхгүй.</p> | <p>Бүрэн хэрэгжсэн<br/>100%</p> |  |
| 53.  | 75. | <p><b>Журам батлах тухай /Иргэнийг цэргийн жинхэнэ албанд эрүүл мэндээр тэнцүүлэх болон цэргийн алба хаагчийн эрүүл мэндийн байдлыг тодорхойлох журам/</b><br/><b>2017.05.17 дугаар 144</b></p> <p>2. журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг МУ-ын Шадар сайд У.Хүрэлсүх, Батлан хамгаалахын сайд Б.Бат-Эрдэнэ, Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Бямбацогт, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.</p>  | <p>2019 оны 2 дугаар ээлжийн цэрэг татлагыг 2019 оны 10-р сарын 10-нд зохион байгуулж, 2 дугаар ээлжийн цэрэг татлагаар 1994-2001 оны 230 цэргийн насны эрчүүд татагдаж, эрүүл мэнд, бие бялдараар 8 хүн тэнцэж цэргийн албан татагдсан.</p>  | <p>Бүрэн хэрэгжсэн<br/>100%</p> |  |

|   |     |   |   |                         |  |
|---|-----|---|---|-------------------------|--|
| 54.   | 76. | <p><b>Мөнгөн төлбөрийн хэмжээ тогтоох тухай.</b><br/>2019.02.27 дугаар 85</p> <p>1. Цэргийн дүйцүүлэх албыг 2019 онд мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний төлөх төлбөрийн хэмжээг 5.334.452 (таван сая гурван зуун гучин дөрвөн мянга дөрвөн зуун тавин хоёр) төгрөг байхаар тогтоосугай.</p> <p>2. Цэргийн дүйцүүлэх албыг хаалгах ажлыг зохих журмын дагуу зохион байгуулж, мөнгөн төлбөрийг төлүүлэх арга хэмжээг авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.</p> | Тайлант хугацаанд 38 иргэнтэй мөнгөн төлбөрийн тооцоо хийж дууссан, мөнгөн төлбөрийн төлбөр төлөх иргэн гараагүй.   | Бүрэн хэрэгжсэн<br>100% |  |
| <b>Дундаж үнэлгээ</b>                                   |     |   |   | <b>100%</b>             |  |
| <b>Найм. Барилга, хот байгуулалтын сайд</b>             |     |   |   |                         |  |
| <b>8.1 Монгол Улсын Засгийн газрын тогтоол</b>          |     |   |   |                         |  |
| 55.   | 77. | <p>Иргэнд 2019 онд өмчлүүлэх газрын нийт хэмжээ, байршил, зориулалтыг тогтоох тухай<br/>2019.03.27 дугаар 119</p> <p>1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын саналыг үндэслэн 2019 онд иргэнд өмчлүүлэх газрын нийт хэмжээ, байршил, зориулалтыг хавсралт ёсоор баталсугай.</p> <p>2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделханд даалгасугай.</p>   | 2019 онд иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар шинээр өмчлүүлэх газар төлөвлөгөө 542 өрхөд 37,94 га биелэлт 60%, иргэнд эзэмшиж буй хашааны газрыг үнэгүй өмчлүүлэх газрыг 44 өрхөд 4.1 га-аас 39 өрхийн 3.5 га газар олгосон. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх зориулалтаар эзэмшүүлэх газар төлөвлөгөө 13.15 га, 1 дуудлага худалдаа зохион байгуулсан. Биелэлт 70%, иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар шинээр эзэмшүүлэх газар төлөвлөгөө 0.07 га, биелэлт 70% , аялал жуулчлалын зориулалтаар 7.5 га, Өвөлжөө, хаваржааны зориулалтаар эзэмшүүлэхээр 4.2 га, биелэлт 70%, тариалангийн зориулалтаар 1.1 га газар олгосон. | Хэрэгжих шатанд<br>70%  |  |
| <b>Дундаж үнэлгээ</b>                                   |     |   |   | <b>70%</b>              |  |
| <b>Ес. Боловсрол, Соёл, шинжлэх ухаан, спортын сайд</b> |     |   |   |                         |  |
| <b>9.1 Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг</b>           |     |   |   |                         |  |
| 56.   | 78. | <p><b>Нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх тухай</b><br/><b>2010.03.26 дугаар 53</b></p>   | Хүүхдийн сонирхол, хэрэгцээнд тохируулан ЕБС-ийн биеийн тамирын багш нар секц, дугуйлан хичээлүүлж, аймаг, бүс, улсын чанартай уралдаан тэмцээнд амжилттай оролцож байна. АБТА Т.Чулуунбор агсны  | Бүрэн хэрэгжсэн<br>100% |  |

|  |     |   |  |  |  |
|--|-----|---|--|--|--|
|  |     | <p>2.Биеийн тамир, спортыг нийтийн үйл хэрэг болгох зорилгоор дунд болон их дээд сургуулиудад биеийн тамир, спортыг сургалтын тэргүүлэх чиглэл болгож сурагч, оюутнуудыг спортоор хичээллэх таатай орчин нөхцлөөр хангах, спортын хамтлаг, клубын тогтолцоог нэвтрүүлж ажиллахыг ТББ, тамирчид, багш дасгалжуулагчид, бизнесийн бүх байгууллага, нийт ард иргэдэд уриалсугай.</p> | <p>нэрэмжит багш нарын аварга шалгаруулах гар бөмбөгийн тэмцээнд эрэгтэй баг хүрэл медаль, эмэгтэй баг хүрэл медаль, багаараа “Нэгдүгээр байр, цом”-ын эзэд боллоо. Хүүхдийн спортын VI их наадмын хөнгөн атлетикийн Аймгийн аварга шалгаруулах тэмцээнд 3 алт, 1 мөнгө, 7 хүрэл медаль, Хүүхдийн спортын VI-р их наадамд 3 сурагч 4-р байр, 1 сурагч “Спортын мастер” цолоо баталж, 1 сурагч “Дэд мастер” –н болзол хангаж багаараа Гутгаар байр, хүрэл медаль хүртсэн. 2019 оны Чөлөөт бөхийн өсвөрийн ААШ тэмцээн Баянгол суманд болж, тус тэмцээнд Бат-Өлзий сумын ЕБС-ийн Д.Бадамбаяр багштай сурагчид нийт 11 медаль хүртэж, эрэгтэй багийн дүнгээр 2-р байр, эмэгтэй багийн дүнгээр 1-р байр эзэлж нийт багийн дүнгээрээ 19 сумын баг тамирчдыг тэргүүлэн Тэргүүн байр эзэлсэн сайхан амжилтыг үзүүллээ. Чөлөөт бөхийн өсвөр үеийн Улын аварга шалгаруулах тэмцээнээс 11а ангийн сурагч Д.Саранцогт Хүрэл медаль хүртсэн. Хүүхдийн спортын 6-р их наадам ААШ сагсан бөмбөгийн тэмцээнд багийн дүнгээр дэд байр эзэлсэн амжилтыг үзүүллээ. 2019 оны УАШ шатрын тэмцээнд 11а ангийн сурагч Б.Цэндэнсодном 9-р байр, ААШ шатрын тэмцээнд Тэргүүн байр, Хүүхдийн спортын 6-р их наадмын шатрын төрөлд 2 алтан медаль, 2 мөнгөн медаль, 1 хүрэл медаль хүртэж 2019 оны аймгийн шилдэг дасгалжуулагчаар дасгалжуулагч багш Н.Ганболд шалгарсан. 2019 оны залуучуудын Улсын аварга шалгаруулах боксын тэмцээнээс Хүрэл медаль хүртсэн амжилт гаргалаа.</p> |  |  |
| <b>9.2 Монгол Улсын Засгийн газрын тогтоол</b> |     |   |  |  |  |
| 57.  | 79. | <p><b>Нийтийн биеийн тамир, спортын талаар авах зарим арга хэмжээний тухай</b><br/> <b>2009.01.07 дугаар 05</b><br/>         6.1 Иргэд биеийн тамир спортоор хичээллэхэд зориулан гүйлт, алхалтын зам, дасгал хөдөлгөөн</p>   | <p>Спорт заал, биеийн тамирын талбай, ногоон байгууламжийн талбайд иргэд биеийн тамир спортоор хичээллэх нөхцөл боломжийг бүрдүүлж өгсөн. “Өглөөний хүн” нарны гүйлтийг 21 хугацаанд амжилттай зохион байгуулсан. Нээлтийн арга хэмжээг</p>  |  |  |

|     |   |  |                      |  |
|-----|---|--|----------------------|--|
|     | хийх ногоон байгууламж бүхий ил талбай байгуулж, өвлийн улиралд байгалийн болон хиймэл мөс, цасан талбайг харъяа нутаг дэвсгэрийнхээ орон сууц, гэр хорооллын орчимд байгуулж, тогтмол ажиллуулах | 2019 оны 6 дугаар сарын 28-нд Хүйтэн булагт зохион байгуулсан. Нээлтийг иргэдийг идэвхижүүлэх, уриалах зорилгоор спорт танин мэдэхүйн тэмцээн хэлбэрээр зохион байгуулсан. Нийт 6 багийн 60 тамирчин хөгжөөн дэмжигч 115 иргэн хамрагдсан. Өглөөний хүн нарны гүйлтийн хаалтын арга хэмжээг 6 дугаар сарын 17-ны өдөр зохион байгуулж, тасралтгүй идэвхитэй оролцсон 7 хүнийг урамшуулж шагнасан. Нарны гүйлтийн арга хэмжээ цаашид тогтмол үргэлжлэн явагдана. “Амьсгалах агаараа тамхинд бүү алд” уриан дор 2 насны ангилалаар нийтийн гүйлтийн тэмцээн зохион байгуулж аврагуудыг шалгаруулсан. Биеийн тамир спортоор хичээллэх, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх мөсөн талбайг ЕБСургуулийн урд талбайд байгуулан хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн ажиллуулж байна. | Бүрэн хэрэгжсэн 100% |  |
| 80. | 6.2 Биеийн тамир, спортын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагын санаачилгыг бүх талаар дэмжиж ажиллах  | “Хангайн хүчтэн дэвжээ” бөхийн холбооны үйл ажиллагааг сумын удирдлагууд, орон нутгийн иргэд дэмжиж, хамтран ажилладаг. 2019 оноос хойш Хангайн хүчтэн дэвжээ 28 удаагийн барилдаан зохион байгуулж, хүүхэд багачуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, улс, аймгийн алдар цолтой бөх төрөх, тив дэлхийд барилдах тамирчдын залгамж халааг бэлтгэх зорилготойгоор ажиллаж байна.   | Бүрэн хэрэгжсэн 100% |  |
| 81. | 6.4 Сумын соёл-спортын төв, аймаг, дүүргийн спортын ордонд иргэд биеийн тамир, спортоор хичээллэх, уралдаан тэмцээн зохион байгуулах таатай орчин бүрдүүлэх арга хэмжээ авах                      | ЕБС-ийн спорт заалыг 50 000 000 төгрөгөөр засварлаж, уралдаан тэмцээн зохион байгуулах таатай орчинг бүрдүүлж, спорт зааланд спортын арга хэмжээ 35 удаа явагдаж, иргэд спортоор хичээллэх, уралдаан тэмцээнд оролцох оролцогчдын тоо нэмэгдсэн. Зохион байгуулсан тэмцээнээс дурьдвал ЕБС, СӨББ-ын эцэг, эхийн гар бөмбөгийн тэмцээн, сумын аварга шалгаруулах гар бөмбөгийн тэмцээн, ЕБС-ийн аварга шалгаруулах, байгууллагын ой, тэмдэглэлт баярын арга хэмжээний уралдаан тэмцээн, сагсан бөмбөгийн тэмцээн, хандивын гар бөмбөгийн тэмцээнүүд тус тус зохион байгуулсан байна. 2018 онд   | Бүрэн хэрэгжсэн 100% |  |

|     |     |   |  |                         |  |
|-----|-----|---|--|-------------------------|--|
|     |     |   | 400 хүний суудалтай шинэ Соёлын төвтэй болж Соёл, урлагийн үйл ажиллагааг зохион байгуулах таатай орчин нөхцөл бүрэн бүрдсэн.  |                         |  |
|     | 82. | 6.5 Улсын хэмжээнд ашиглагдаж байгаа нийтийн биеийн тамир, спортын заал, танхим, гадна талбайн ашиглалтыг сайжруулах, цаашид зориулалтыг өөрчлөх, бусдад шилжүүлэх, худалдахыг хориглох чиглэлээр тодорхой арга хэмжээ авах.  | ЕБС-ийн спорт заалыг зориулалтын дагуу ашиглаж, жил бүр урсгал засвар хийж, спорт заалыг зориулалтын дагуу ашиглаж байна.  | Бүрэн хэрэгжсэн<br>100% |  |
| 58. | 83. | Хувьсах зардлын дундаж норматив, санхүүжүүлэх аргачлал батлах тухай /хүүхдийн хоол/ 2016.05.02 №242<br>2. Нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативт зардлыг батлагдсан аргачлалын дагуу санхүүжүүлж байхыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Л.Гантөмөр, Сангийн сайд Б.Болор, бүх шатны Засаг дарга нарт даалгасугай.   | Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлыг нэг хүүхэд өдөрт 1650 төг, ЕБС-ийн дотуур байрны нэг хүүхдэд нэг өдөр 2315 төг, 1-5-р ангийн хүүхдэд нэг өдөр 600 төгрөгөөр хүүхэд-өдрөөр тоцон өдөр бүр баталгаажуулан нормын дагуу хүүхдийг хооллож байна. Дотоод хяналтын комиссын гишүүд нь 7 хоног бүр хүүхдийн хоолны норм, орчны эрүүл ахуй, хүнсний бүтээгдэхүүний хадгалалтын байдал, ажиллагсад болон бүтээгдэхүүний эрүүл ахуйн шинжилгээ хийлгэсэн эсэхэд хяналт тавьж хэвшсэн. 2019 оны хичээлийн жилд 1 дүгээр цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардалд 48217470 төгрөг, 2 дугаар цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардалд 24569000 төгрөг, ЕБС-ийн дотуур байрны хүүхдийн хоолны зардалд 28403465 төгрөг, үдийн цайны зардалд 26700375 төгрөг шилжүүлсэн. | Бүрэн хэрэгжсэн<br>100% |  |
| 59. | 84. | <b>“Улсын болон орон нутгийн номын сангийн сан хөмрөгийг байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюулын үед нүүлгэн шилжүүлэх журам батлах тухай 2016.05.31 №288</b><br>2. Байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюулын үед улсын болон орон нутгийн номын санг нүүлгэн шилжүүлэх ажлын бэлтгэлийг сайтар хангуулж, хяналт тавьж ажиллахыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Л.Гантөмөрт, бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай. | Байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюулын үед Соёлын төвийн номын санг нүүлгэн шилжүүлэх ажлын бэлтгэлийг сайтар хангаж, журмыг мөрдөж ажиллах үүрэг чиглэл өгч, хяналт тавин ажиллаж байна.   | Бүрэн хэрэгжсэн<br>100% |  |



|     |     |   |  |                         |  |
|-----|-----|---|--|-------------------------|--|
| 60. | 85. | <p><b>Монгол хэл бичгийн боловсролыг сайжруулах арга хэмжээний тухай</b><br/> <b>2013.02.02 дугаар 37</b></p> <p>4. Төрийн албан хэрэг хөтлөлтийн стандартыг бүх шатанд мөрдлөг болгож төрийн албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авахыг ЗГ-ын гишүүн, ЗГ-ын агентлагийн дарга, бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай.</p> <p>5.Хот, суурин газрын төрийн болон хувийн хэвшлийн бүх байгууллагын хаяг, зар сурталчилгааг монгол кирил бичгээр бичиж байхыг бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай.</p> | <p>“Төрийн албан хэрэг хөтлөлтий үндсэн заавар”, “Баримт бичгийн стандарт”, “Байгууллагын архивын ажлын зохион байгуулалт” сэдвээр 6 байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан 6 албан хаагчдад сургалт, мэдээлэл өгсөн.</p> <p>Хувийн хэвшлийн байгууллагуудад хаяг, зар сурталчилгааг Монгол кирил бичгээр бичиж байхыг анхааруулж албан тоот хүргүүлэн хяналт тавин ажиллаж байна. 2019 оны 05 дугаар сарын 16-нд Эрүүл мэндийн төвийн албан хаагчдад “Албан хэрэг хөтлөлтийн стандарт” сэдвээр сургалт явуулж албан хаагчдын албан хэрэг хөтлөх зохих мэдлэг чадварыг дээшлүүлсэн. 2019 оны 1 дүгээр сард архив, албан хэрэг хөтлөлтийн сургалтанд ЕБСургуулийн архив, бичиг хэргийн ажилтанг сургалтанд хамруулж, мэдлэг чадварыг дээшлүүлсэн.</p> <p>“Үндэсний өв соёлоо тээгч, түгээгч” монгол бичгийн анги нийтийн олимпиадад ЕБС-ийн Ц.Мөнхцэцэг багшийн бэлдсэн 116 анги аймагт 3 дугаар байр, улсад 14 дүгээр байр, Э.Болормаа багшийн бэлдсэн 9а анги улсад 14 дүгээр байр, аймагт 5 дугаар байр тус тус эзэлсэн. Монгол Улсын Ерөнхий сайдын ивээл дор зохион байгуулагддаг Монголын сайхан бичигтэн улсын уралдаанд 96 ангийн сурагч Аривжихсүрэн 116 ангийн Гончигсүрэн нар улсад тусгай байранд шалгарсан. Ц.Мөнхцэцэг багшийн бэлтгэсэн шавь нар нь Монгол туургатны “Миний монгол бичиг” олон улсын уралдаанд 3 дугаар байранд шалгарсан. Аймгийн БСУГ-аас зохион байгуулсан нэрээ монгол бичгээр бичиж, гарын үсгээ монгол бичгээр бичих аяныг хамт олонд сурталчилж багш ажилтнууд нэр, гарын үсгээ монгол бичгээр бичиж сурч байна.</p> | Бүрэн хэрэгжсэн<br>100% |  |
| 61. | 86. | <p>Төрөөс биеийн тамир, спортын талаар баримтлах бодлого батлах тухай<br/> 2019.04.17 дугаар 153</p>  | <p>Биеийн тамир, спортын талаар баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулсан. Хүүхдийн сонирхол, хэрэгцээнд тохируулан ЕБС-ийн биеийн</p>  | Бүрэн хэрэгжсэн<br>100% |  |

|  |  |   |  |  |
|--|--|---|--|--|
|  | <p>3. “Төрөөс биеийн тамир, спортын талаар баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг Монгол Улсын нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгаж, улс, орон нутгийн төсөв, гадаад, дотоодын зээл тусламж, төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд шийдвэрлэхийг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэг, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.</p> | <p>тамирын багш нар секц, дугуйлан хичээлүүлж, аймаг, бүс, улсын чанартай уралдаан тэмцээнд амжилттай оролцож байна. АБТА Т.Чулуунбор агсны нэрэмжит багш нарын аварга шалгаруулах гар бөмбөгийн тэмцээнд эрэгтэй баг хүрэл медаль, эмэгтэй баг хүрэл медаль, багаараа “Нэгдүгээр байр, цом”-ын эзэд боллоо. Хүүхдийн спортын VI их наадмын хөнгөн атлетикийн Аймгийн аварга шалгаруулах тэмцээнд 3 алт, 1 мөнгө, 7 хүрэл медаль, Хүүхдийн спортын VI-р их наадамд 3 сурагч 4-р байр, 1 сурагч “Спортын мастер” цолоо баталж, 1 сурагч “Дэд мастер” –н болзол хангаж багаараа Гутгаар байр, хүрэл медаль хүртсэн. 2019 оны Чөлөөт бөхийн өсвөрийн ААШ тэмцээн Баянгол суманд болж, тус тэмцээнд Бат-Өлзий сумын ЕБС-ийн Д.Бадамбаяр багштай сурагчид нийт 11 медаль хүртэж, эрэгтэй багийн дүнгээр 2-р байр, эмэгтэй багийн дүнгээр 1-р байр эзэлж нийт багийн дүнгээрээ 19 сумын баг тамирчдыг тэргүүлэн Тэргүүн байр эзэлсэн сайхан амжилтыг үзүүллээ. Чөлөөт бөхийн өсвөр үеийн Улын аварга шалгаруулах тэмцээнээс 11а ангийн сурагч Д.Саранцогт Хүрэл медаль хүртсэн. Хүүхдийн спортын 6-р их наадам ААШ сагсан бөмбөгийн тэмцээнд багийн дүнгээр дэд байр эзэлсэн амжилтыг үзүүллээ. 2019 оны УАШ шатрын тэмцээнд 11а ангийн сурагч Б.Цэндэнсодном 9-р байр, ААШ шатрын тэмцээнд Тэргүүн байр, Хүүхдийн спортын 6-р их наадмын шатрын төрөлд 2 алтан медаль, 2 мөнгөн медаль, 1 хүрэл медаль хүртэж 2019 оны аймгийн шилдэг дасгалжуулагчаар дасгалжуулагч багш Н.Ганболд шалгарсан. 2019 оны залуучуудын Улсын аварга шалгаруулах боксын тэмцээнээс Хүрэл медаль хүртсэн амжилт гаргалаа.</p> |  |  |
| Дундаж үнэлгээ                         |  | 100%  |  |  |
| Арав. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд |  |   |  |  |
| 10.1 Засгийн газрын тогтоол            |  |   |  |  |

|   |     |  |  |                                 |  |
|---|-----|--|--|---------------------------------|--|
| 62.   | 87. | <p><b>“Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам</b><br/> <b>2017.05.24. дугаар 151</b></p> <p>4. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомжийг сурталчлан хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж, Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Б.Баатарцогт нарт, журмын хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Н.Цагаанхүүд, журмыг хэрэгжүүлэх ажлыг харьяа нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулж ажиллахыг бүх шатны Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.</p> | <p>Журмыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд тогтоолыг хяналтад авч, Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомжийг багуудын иргэдийн Нийтийн Хурлаар иргэдэд сурталчилсан. Сурталчилгаанд 800 гаруй иргэн хамрагдсан.</p>  | <p>Бүрэн хэрэгжсэн<br/>100%</p> |  |
| Дундаж үнэлгээ  |     |  |  | 100%                            |  |
| <b>Арван нэг. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд</b> |     |  |  |                                 |  |
| <b>11.1 Монгол Улсын Засгийн газрын тогтоол</b>               |     |  |  |                                 |  |
| 63.   | 88. | <p><b>Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам,</b><br/> <b>2016.03.14 дугаар 153</b></p> <p>2. Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан журмыг хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.</p>  | <p>Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс тогтоосон товын дагуу 2019 оны 5 дугаар сарын 15-нд төсөл сонгон шалгаруулах ажлын хэсэг хуралдаж, Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс нийт 82.0 сая төгрөгийг 16 иргэнд олгосон. Сум хөгжүүлэх сангийн зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавьж, Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэлтэй 16 иргэний 34503215 төгрөг байгаа ба дээрх зээлдэгчдэд хугацаатай албан мэдэгдэл өгч, мэдэгдлийн хугацаанд зээлээ барагдуулаагүй тохиолдолд Шүүхэд шилжүүлэхийг албан ёсоор мэдэгдэж, баталгаа гаргуулсан.</p> | <p>Хэрэгжих шатанд<br/>70%</p>  |  |
| 64.   | 89. | <p><b>Хөдөө аж ахуйн ээлжит тооллого явуулах тухай</b><br/> <b>2012.04.25 дугаар137</b></p> <p>3. Хөдөө аж ахуйн ээлжит тооллого, судалгаа явуулахтай холбогдуулан харьяа нутаг дэвгэртээ тооллого явуулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулан, хөдөө аж ахуйн үйл ажиллагаа явуулж</p>  | <p>Хагас жилийн мал тооллогын түүвэр судалгааг зохион байгуулах ажлын хэсгийг Засаг даргын 2019 оны 6 дугаар сарын 03-ны өдрийн а/75 дугаар захирамжаар томилон 2019 оны 06 дугаар сарын 03-наас 06 дугаар сарын 10-ны хооронд зохион байгуулж, тооллогод 238 өрх хамрагдаж 71784 мал тоолж, холбогдох тайланг</p>   | <p>Бүрэн хэрэгжсэн<br/>100%</p> |  |

|     |     |  |  |                         |  |
|-----|-----|--|--|-------------------------|--|
|     |     | байгаа өрх, аж ахуйн нэгжийг тооллогод бүрэн хамруулах арга хэмжээ авч, тооллогын ажилд удирдлага, зохион байгуулалтын дэмжлэг үзүүлж ажиллахыг бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай.   | аймгийн Статистикийн хэлтэст хүргүүлсэн. Мал тооллогын зардалд 1140362 төгрөг зарцуулав.   |                         |  |
| 65. | 90. | Малчдын хоршоог хөгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай.<br><b>2013.01.12 дугаар 08</b><br>3.Хоршооны хөдөлмөрийн давуу тал, ач холбогдлыг орон нутагт сурталчлан хэрэгжүүлэх арга хэмжээг хоршооллын болон хоршоог дэмжигч бусад байгууллагатай хамтран зохион байгуулахыг аймаг, сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.  | 2019 оны 5 дугаар сарын 2-нд Бат-Өлзий суманд “Хамтын хүч хоршоо” гишүүдээ чадавхжуулах зорилгоор ЧИ-ТА төсөлд хандан мэргэжлийн сургагч багшаар “Бизнес төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулах” сургалтанд 30 гишүүнээ хамруулсан. Аймагт зохион байгуулагдсан “Малчдын зөвлөгөөн”-нд сумын малчид болон малчдын хоршооны төлөөлөл 20 иргэнийг оролцуулсан. Энэ үеэр Хөдөө аж ахуйн хөдөлмөр хөнгөвчилсөн үзэсгэлэн худалдаанд “Хамтын хүч” хоршоо мод, модон эдлэлийн төрөлд андуу, бүрхээр, хувин зэрэг бүтээгдэхүүнээр, суран эдлэлийн төрлөөр элдэж сүлжсэн бүтээгдэхүүнээр оролцож Мод, модон эдлэлийн бүтээгдэхүүн “Тэргүүн байр”, сур, суран эдлэлийн бүтээгдэхүүн “Тусгай байр” эзэлж, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдсан. ӨВ ТҮНШЛЭЛ-2019 үзэсгэлэн худалдаанд оролцож, Хангайн бал хоршоо “Хүнсний шилдэг бүтээгдэхүүн” шагнал, 4 дүгээр багийн иргэн Ганболдын хар ухна шилмэл хээлтүүлэгчийн төрөлд 2-р байрт шалгарсан. | Бүрэн хэрэгжсэн<br>100% |  |
| 66. | 91. | <b>Хүнсний зориулалтын бус хуванцар савны талаар авах зарим арга хэмжээний тухай</b><br><b>2015.12.14 дугаар 496</b><br>3. Хүнсний зориулалтын бус хуванцар савыг хүнсний худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, сургууль, цэцэрлэг, эмнэлгийн газарт хоол, хүнсний савлагаанд хэрэглэхийг хориглож, хэрэгжилтэд нь холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, мэргэжлийн холбоодтой хамтран хяналт тавьж ажиллан, энэ тухай нийтэд мэдээлэл, сэрэмжлүүлэг түгээж, сургалт, сурталчилгаа зохион байгуулахыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Р.Бурмаа, | Суманд 400 малчны зөвлөгөөн зохион байгуулагдаж, зөвлөгөөний хөтөлбөрт “Хүнсний бус хуванцар сав, хуванцар савны хэрэглээ ба хор хөнөөл, хуванцар савны таних тэмдэг, хуванцар саван дахь чимээгүй хор” сэдвээр мэдээлэл сурталчилгаа хийсэн. Мөн энэ талаар мэдээлэл бэлтгэн албан байгууллага, аж ахуйн нэгжүүдийн албан хаагчдад, БИНХурлаар мэдээлэл хийсэн. Мэдээлэл сурталчилгаанд 700 гаруй иргэн хамрагдсан. Албан байгууллага, аж ахуйн нэгжүүд гал тогоондоо хүнсний зориулалтын савыг ашигладаг болсон. Цаашид бүх өрхүүдийг хуванцар савнаас   | Хэрэгжих шатанд<br>70%  |  |

|     |     |   |   |                         |  |
|-----|-----|---|---|-------------------------|--|
|     |     | Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Ш.Раднаасэд болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.  | татгалзаж, зориулалтын савыг ашигладаг болгох зорилт тавин ажиллаж байна.   |                         |  |
| 67. | 92. | <p><b>Хөрс хамгаалах өдөртэй болох тухай 2017.05.24 дугаар 149</b></p> <p>1. Жил бүрийн 5 дугаар сарын эхний 7 хоногийн Бямба гарагийг “Хөрс хамгаалах үндэсний өдөр” болгон тэмдэглэж байхаар тогтоосугай.</p> <p>2. “Хөрс хамгаалах үндэсний өдөр”-ийг уул уурхай, газар тариалан, мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлдэг болон газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хөрс хамгаалах, түүнийг нөхөн сэргээх, хот, суурин газрын хөрсний бохирдлыг бууруулах, саармагжуулах талаар тухайн жилд зохион байгуулах ажил, арга хэмжээг төлөвлөж, тэдгээрийг олон нийтэд таниулан сурталчлах ажлыг холбогдох төрийн захиргааны төв байгууллага аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газартай хамтран жил бүр зохион байгуулах замаар тэмдэглэн өнгөрүүлж байсугай.</p> | “Хөрс хамгаалах үндэсний өдөр”-ийг тохиолдуулан Бат-Өлзий суманд бүх нийтийн хог цэвэрлэгээг зохион байгуулж, сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж байгаа албан байгууллага, аж ахуйн нэгж, худалдаа, үйлчилгээний газрууд, иргэд нийтийн эзэмшлийн зам талбай болон гудамж, хороолол, далан гуу жалга, хогийн цэгийн хур хогийг цэвэрлэж, хог хаягдлыг ачиж, тээвэрлэж ажиллаа. Сумын хэмжээнд нийт 47 га талбайг хамруулан цэвэрлэж, нийт 900 гаруй хүн их цэвэрлэгээнд оролцон 34 рейсээр 180 тн хогийг цэвэрлэлээ. Хуучин хогийн цэгийн хур хогийг хумих, дарах ажлыг гэрээгээр гүйцэтгүүлж байна. Олон нийтийн сүлжээгээр “Хөрс хамгаалах үндэсний өдөр”-өөр хөрс хамгаалах, түүнийг нөхөн сэргээх, газрын хөрсний бохирдлыг бууруулахад иргэн бүр анхаарч, зохион байгуулж буй арга хэмжээнд оролцохыг уриалж, энэ талаар олон нийтэд мэдээлэл хүргэсэн. | Бүрэн хэрэгжсэн<br>100% |  |
| 68. | 93. | <p>“Атар-60” бүтээлч ажил өрнүүлэх тухай 2018.03.14 дугаар 76</p> <p>3. “Атар-60” бүтээлч ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг аймаг, нийслэлийн Засаг дарга нартай хамтран үр дүнтэй, шуурхай зохион байгуулж, явц, дүнг Засгийн газарт танилцуулж байхыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Б.Батзоригт даалгасугай.</p>  | Монгол улсад атар газар эзэмшиж газар тариаланг бие даасан салбар болгон хөгжүүлсний түүхт 60 жилийн ойн арга хэмжээний хүрээнд 8 заалт бүхий хийх ажлын төлөвлөгөө гаргаж, сумын Засаг даргаар батлуулсан. 2019 оны 5-р сарын 10-нд Арвайхээр суманд болсон нээлтийн арга хэмжээнд сумын Засаг дарга газар тариалангийн салбар хариуцсан мэргэжилтэн, тариаланч В.Буянтогтох, Ч.Мягмарсүрэн, Б.Отгон нар оролцсон. Тус ойг тохиолдуулан ойн медиальд 15 тариаланч тодорхойлж, ХХААХҮЯ-ны хүндэт жуухд Д.Отгонсүрэн, ХХААСалбарын тэргүүний ажилтан цол тэмдэгээр Ж.Батсүх, Атарчны алдар цол тэмдэгээр Д.Нансалмаа нар шагнагдсан. Мөн Хархорин суман зохион байгуулагдсан газар тариалан эрхлэгчдын ур чадварын уралдаан, агрономчдын ажил мэргэжилийн  | Бүрэн хэрэгжсэн<br>100% |  |

|     |     |   |  |                      |  |
|-----|-----|---|--|----------------------|--|
|     |     |   | уралдаан, жимс жимсгэнэ, хөрс хамгаалал, бордоо, ургамал хамгааллын бодисын талаар, үр тарианы технологийн талаар танилцуулга мэдээлэл, шинэ технологийн үзүүлэх сургалт зэрэг нэгдсэн зохион байгуулалт болж 15 тариаланчыг хамруулан Ч.Мягмарсүрэн уран хагалгааны төрөлд амжилттай оролцсон."Өвөрхангай Түншлэл-2019" намрын баяр үзэсгэлэн худалдаанд Д.Отгонсүрэн, Ж.Батсүх нар даршилсан ногоо болон бөөрөнхий сонгины төрлөөр амжилттай оролцсон.   |                      |  |
| 69. | 94. | Бэлчээр хамгааллын ажлыг эрчимжүүлэх тухай 2019.05.01 дугаар 185<br>4. 2019 оны бэлчээр хамгааллын арга хэмжээг нийтийг хамарсан ажил болгон зохион байгуулах, цаашид жил бүрийн 5 дугаар сарын эхний долоо хоног болон 10 дугаар сарын сүүлийн 7 хоногийн Баасан, Бямба, Ням гарагийг "Бэлчээр хамгаалах өдөр" болгон зарлаж, мэрэгч амьтан, шавжны хөнөөлөөс бэлчээрээ хамгаалах бүх нийтийн арга хэмжээг сум, багийн түвшинд зохион байгуулж байхыг аймгийн Засаг дарга нарт үүрэг болгосугай. | Бэлчээрийг зүй зохисой ашиглах, хамгаалах чиглэлээр малчид иргэдэд мэдээлэл, зөвлөгөөг өгч, жил бүр сумын Засаг даргын захирамжаар өвөлжөө, хаваржааны бэлчээрийг чөлөөлөх, өнжөөх, сэлгээх шийдвэрийг гаргаж, багийн Засаг дарга нар, иргэд мөрдөж, хэрэгжүүлэн ажиллаж байна. Сумын нутаг дэвсгэрийн бэлчээрийн хор хөнөөлын судалгаагаар бэлчээрийн мэрэгч амьтан, шавж илрээгүй. Жил бүрийн 6 дугаар сарын 1-ээс 9 дүгээр сарын 18-ны хугацаанд 4-р баг бүрэн, 3,5 дугаар багууд бүрэн, 1,2 дугаар багууд хэсэгчилсэн байдлаар өвөлжөө, хаваржааны бэлчээрийг чөлөөлж, 1 дүгээр багийн Уурагт, 4 дүгээр багийн Бөхөн шар, Урд агуйт, Хойд агуйт, 2 дугаар багийн Байшинт, Хонгор, Шийрт, Жаргалант, 5 дугаар багийн Өвт гэх газруудын хадлангийн талбайг сэргээх зорилгоор малаас чөлөөлж, 17 га хадлангийн талбай хашиж хамгаалсан. | Бүрэн хэрэгжсэн 100% |  |
| 70. | 95. | Хөдөө аж ахуйн салбарын 2019-2020 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай 2019.07.03 дугаар 285<br>3. Өвөл, хаврын цаг агаарын хүндрэл, болзошгүй гамшиг тохиолдохоос урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх зорилгоор дараах ажлыг зохион байгуулж ажиллахыг аймаг,   | "Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах тухай" сумын Засаг даргын 2019 оны 08 дугаар сарын 21-ны өдрийн А/113 дугаар захирамж гаргаж, захиармжийн 1 дүгээр хавсралтаар өвөлжилтийн бэлтгэл ажлыг зохион байгуулах ажлын хэсэг, 2 дугаар хавсралтаар 2019-2020 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах ажлын төлөвлөгөө, 3 дугаар хавсралтаар өвс, тэжээлийг хангах хувиарлалтыг тус тус баталсан. Батлагдсан төлөвлөгөөний дагуу хийсэн ажлыг аймгийн   | Бүрэн хэрэгжсэн 100% |  |

|     |  |  |                                 |  |
|-----|--|--|---------------------------------|--|
|     | <p>нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт даалгасугай:</p> <p>3.1. Хөдөө аж ахуйн салбарын 2019-2020 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах талаар нарийвчилсан төлөвлөгөө гарган ажиллаж, хэрэгжилтийг хангуулах, биелэлтэд хяналт тавих, шаардлагатай арга хэмжээг авах</p> | <p>ХХААГазар, аймгийн ОБГазарт 09 дүгээр сарын 15, 10 дугаар сарын 01-ны өдрүүдэд файл хэлбэрээр хүргүүлж өвөлжилтын бэлтгэл ажлыг хангах төлөвлөгөөний дагуу хийсэн ажлын тайланг баталгаажуулан 10 дугаар сарын 28 нд ХХААГазарт хүргүүлсэн.</p>   |                                 |  |
| 96. | <p>3.2. Энэ тогтоолын хавсралтаар батлагдсан аймаг, нийслэл, сум, дүүргийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг заасан хэмжээнд бүрдүүлэх;</p>  | <p>Малчдын түвшинд нийт 5208 тн өвс, 2574 тн гар тэжээл бэлтгэхээс 4000тн өвс, 1200тн гар тэжээл, 729тн хужир биелэлт 87% тай, сумын аюулгүй нөөцөд 2008 тн өвс, 5тн хорголжин хэвэгний нөөцөлсөн 100 хувийн биелэлттэй. Албан байгууллагууд гар тэжээл бэлтгэх төлөвлөгөөг байгууллагын ажилчдаас бэлэн мөнгө хураан авч мал хамгаалах санд төвлөрүүлсэн.</p>   | <p>Бүрэн хэрэгжсэн<br/>100%</p> |  |
| 97. | <p>3.3. Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах эм, эмнэлгийн хэрэгслээр хүртээмжтэй хангах, мал, эмнэлгийн үйлчилгээг шуурхай, чанартай зохион байгуулахад хяналт тавих;</p>  | <p>2019 онд малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх боом, дотрын халдварт хордлого, цусан халдварт, галзуу, дотрын халдварт хордлого, энтеробактериозын 8 төрлийн вакциныг нийт мал сүргийн 12,6%-д буюу 38000 мянган толгой малд хийх төлөвлөгөөтэйгээс 8 төрлийн вакциныг татан авч гүйцэтгэл 94%-ийн гүйцэтгэлтэй. Төл малын бруцеллёзын вакцинд 60420 мянган толгой төлийг хамруулах төлөвлөгөөтэйгээс 100% хийж гүйцэтгэсэн.</p> | <p>Бүрэн хэрэгжсэн<br/>100%</p> |  |
| 98. | <p>3.4. Бэлчээрийн даацад тулгуурлан аймаг, сум дундын отрын бүс нутаг, улсын хилийн зурвас болон байгалийн тусгай хамгаалалттай газар нутагт отроор өвөлжүүлэх малчин өрх, мал сүргийн тоо толгойг харилцан тохиролцож гэрээ байгуулан ажиллах;</p>                             | <p>Сумын хэмжээнд 1259 өрхийн Адуу-30108, Үхэр-44988, Хонь-125466, Ямаа-100067 нийт <b>300629</b> толгой мал өвөлжихөөр байна. Үүнээс өөр аймгийн нутагт 9 өрхийн нийт 8000 гаруй толгой мал өвөлжих судалгаатай. 1-р баг Цагаан азаргын 2202 га талбайг отрын бүсээр хяналтандаа авч, цаг хүндэрсэн үед отроор мал оруулахаар төлөвлөсөн.</p>   | <p>Бүрэн хэрэгжсэн<br/>100%</p> |  |
| 99. | <p>3.5. Хадлангийн талбайг оновчтой хуваарилах, зохистой ашиглах, говийн бүсийн болон хадлангийн нөөц багатай аймгуудад хадлан бэлтгэх талбайг гэрээгээр ашиглуулах, хадлан, гар тэжээл бэлтгэх ажлыг технологит хугацаанд нь чанартай гүйцэтгэх ажлыг бүх талаар дэмжих;</p>    | <p>Бэлчээрийн “Ногоон алт” төсөлтэй хамтран малчдын бүлгүүдийг нэгтгэж сумын бэлчээр ашиглалтын 8 хэсэг байгуулж, 3, 5, 2-р багийн иргэдтэй бэлчээр ашиглалтын загвар гэрээ байгуулан доройтсон бэлчээрийг сэлгэн өнжөөж, хашиж хамгаалах,</p>   | <p>Хэрэгжих шатанд<br/>70%</p>  |  |

|      |   |  |                      |  |
|------|---|--|----------------------|--|
|      |   | хадлангийн талбайн ашиглалтыг сайжруулах ажлыг зохион байгуулж, хамтран ажиллаж ажиллаж байна.   |                      |  |
| 100. | 3.6. Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг технологит хугацаанд нь чанартай зохион байгуулах, мал эмнэлгийн дуудлага, үйлчилгээний бэлэн байдлыг бүрдүүлж, шуурхай удирдлагаар хангах;   | Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх тарилга туулгыг заасан хугацаанд чанартай гүйцэтгэн, мал, амьтны халдварт өвчний тайван байдлыг хадгалан ажиллаж байна. “Санги хайрхан”, “Хустын рашаан” Мал эмнэлгийн нэгжүүд мал эмнэлгийн дуудлага, үйлчилгээний бэлэн байдлаа шалгуулж, 70 хувиас дээш хангалттай үнэлгээ авч, бэлэн байдлыг ханган ажиллаж байна.   | Бүрэн хэрэгжсэн 100% |  |
| 101. | 3.7. Малчин өрх бүр өвөлжөө, хаваржаан дахь орон сууц (гэр, байшин), малын хашаа, хороо, саравч, худаг, уст цэгээ сэргээн засварлах, цаг агаар хүндэрсэн үед хэрэглэх тоног хэрэгсэл, дулаан хувцас, хоол хүнс, түлээ, нүүрс зэрэг өрхийн бэлтгэл хангуулах тухай зөвлөмж гаргаж ажиллах; | 2019 оны 8 дугаар сарын 21, 22-нд Сумын ИТХуралтай хамтран “Төрийн үйлчилгээг малчны хотонд “Бичил төслийн хүрээнд 1, 2, 3, 4, 5-р багуудын 180 гаруй малчин өрхөд ХХААХҮСайдын 2019 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 285 дугаар тогтоол, сумын Засаг даргын захирамж, өвөлжилтийн бэлтгэл ажлын талаар, Мөн 2019 оны 10 дугаар сарын 30-ас 11 дүгээр сарын 04-ний хооронд БИНХурлууд зохион байгуулагдаж 450 гаруй малчдад зөвлөмж өгч мэдээлэл хийсэн. | Бүрэн хэрэгжсэн 100% |  |
| 102. | 3.8. Мал, мах бэлтгэх, нийлүүлэх ажлыг аймаг, орон нутгийн хэрэгцээ, зах зээлийн эрэлтэд тулгуурлан зохион байгуулах ажлын төлөвлөгөө батлан, хэрэгжилтийг зохион байгуулах;  | Багийн иргэдийн нийтийн хурлуудаар малчдад мал, мах бэлтгэх, нийлүүлэх ажилд хамтран ажиллах санал тавьж, мэдээлэл өгсөн. Аймаг, орон нутгийн махны үйлдвэр зах зээлийн үнэ ханшнаас доогуур үнээр худалдан авалт хийж байгаа болохоор малчид шууд мал махны ченжүүдэд мал, махаа нийлүүлж байна. Энэ асуудлыг төрөөс бодлогоор зохицуулж өгөх шаардлагатай байна.   | Хэрэгжих шатанд 70%  |  |
| 103. | 3.9. Ургац хураалтад ажиллах хүн хүч, техникийн бэлэн байдлыг хангах, цаг агаарын гамшигт үзэгдлээс ургацаа хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмол зохион байгуулах.   | 5-р багийн хүйтэн булгийн 10 га ногооны талбайд 24 иргэн тариалалт хийж, 8,5 га-д төмс, 2,4 га-д хүнсний ногоо тарьж, 93 тн төмс, 28 тн хүнсний ногоо хураан авч, Малчдын хамтын хүч хоршоо нь Хүйтэн булгийн 2 га талбайд малын ногоон тэжээл тариалж 5 тн хураан авч, царгасыг дараа жил хураан авахаар өнжөөсөн.  | Бүрэн хэрэгжсэн 100% |  |



|   |      |  |  |                         |  |
|---|------|--|--|-------------------------|--|
| 71.   | 104. | Журам шинэчлэн батлах тухай<br>2019.09.04 дугаар 343<br>1. “Хонь, тэмээний ноос бэлтгэж, үндэсний үйлдвэрт тушаасан малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох журам”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.   | Бат-Өлзий сумын 155 өрхийн 26364 кг ноосны урамшуулал олгох анхан шатны баримтыг бүрдүүлэн аймгийн ХХААГазарт хүргүүлсэн.  | Хэрэгжих шатанд<br>70%  |  |
| <b>Дундаж үнэлгээ</b>                           |      |  |  | <b>92,5%</b>            |  |
| <b>Арван хоёр. Эрүүл мэндийн сайд</b>           |      |  |  |                         |  |
| <b>12.1 Монгол Улсын Засгийн газрын тогтоол</b> |      |  |  |                         |  |
| 72.   | 105. | <b>Архидан согтуурахтай тэмцэх, архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх талаарх төрийн захиргааны байгууллагын зарим чиг үүргийг төрийн бус байгууллагад хариуцуулан гүйцэтгүүлэх тухай</b><br><b>2008.06.11 дугаар 238</b><br>2. “Архидалт мансуурлын эсрэг ассоциаци” төрийн бус байгууллагыг сургалт, сурталчилгаа явуулах, цуглаан хийх байраар тухай бүр хангаж байхыг аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нарт даалгасугай.                | Суманд үйл ажиллагаа явуулж байгаа АА-н “Цагаан зам”, “Зөв зам” бүлэг, давхар хамаарлын Ал-аноны “Ариун сэтгэл”, “Аз жаргалын зам” бүлүүд нь 7 хоног бүр 2-3 удаа тогтмол цуглаан, уулзалт зохион байгуулж үйл ажиллагаа нь жигдэрсэн. Цуглаанд оролцох хүсэлтэй иргэд нэмэгдэж 2019 оны 5 дугаар сарын 3-нд “Зөв зам” АА бүлийн 1 жилийн ой, 5 дугаар сарын 11-нд эмэгтэйчүүдийн “Аз жаргалын зам” бүлийн 1 жилийн ойн арга хэмжээний нээлттэй цуглаан тус тус зохион байгуулагдаж, нийгэмд архины эсрэг эерэг зөв хандлагыг сурталчилсан арга хэмжээг сумын ГХУСАЗСалбар зөвлөл дэмжиж, хамтран ажилласан. АА бүлүүдийн цуглаан хийх байрны асуудлыг ИТХурлаас шийдвэрлэн өгсөн. | Бүрэн хэрэгжсэн<br>100% |  |
| 73.   | 106. | <b>Давсны хэрэглээг бууруулах үндэний стратеги батлах тухай</b><br><b>2015.08.31 дугаар 353</b><br>3. Үндэсний стратегийг хэрэгжүүлэх арга хэмжээг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд, шаардагдах хөрөнгийг улсын болон орон нутгийн төсөвт тусгаж, гадаад орон, олон улсын байгууллагын зээл, тусламжид хамруулах замаар санхүүжүүлж ажиллахыг ЭМССайд, Сангийн сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай. | Эрүүл мэндийн төв “Давсны хэрэглээгээ бууруулцаая” уриалга гаргаж, 9 гал тогоо бүхий газруудад байршуулсан. Цайны газар, албан байгууллагын тогооч 12 хүнд сургалт зохион байгуулж, гарын авлага тараасан. “Давс бага хэрэглэе” сэдэвт сургалтыг ЕБС-ийн 9, 10 ангийн нийт 150 сурагч, 15 эмч, ажилчдад сургалт зохион байгуулж, анги бүрийн мэдээллийн самбарт байршуулсан.<br>ЭМТөвийн явуулын амбулаторын баг 5 багт ажиллаж 250 хүнд цайгаа давсгүй уух, давсны хэрэглээгээ багасгах талаар зөвлөгөө өгсөн.  | Бүрэн хэрэгжсэн<br>100% |  |
| 74.   | 107. | <b>Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого батлах тухай</b>  |  |                         |  |

|  |      |   |  |                                 |  |
|--|------|---|--|---------------------------------|--|
|  |      | <p><b>2017.01.18 дугаар 24</b></p> <p>2. Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг улсын хэмжээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн сайд А.Цогцэцэгт, эрхэлсэн салбар, харьяа нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.</p> <p>3. Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээг Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэлд, шаардагдах хөрөнгийг улсын болон орон нутгийн төсөвт жил бүр тусгаж гадаад улс, олон улсын байгууллагын зээл, хандив, тусламжид хамруулах замаар санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Чойжилсүрэн, Эрүүл мэндийн сайд А.Цогцэцэг, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.</p> | <p>Сумын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлж, иргэдийг жил бүр урьдчилан сэргийлэх, үзлэг шинжилгээнд хамруулж, эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагааг эрчимжүүлэн ажиллаж байна. Сумын Эрүүл мэндийн төвд шаардлагатай боловсон хүчин, техник хэрэгсэлийг шийдвэрлэн 2019 онд Микроскоптой болох зорилт тавин ажиллаж хөрөнгийн асуудлыг шийдвэрлэсэн. 2019 оны 12 дугаар сарын 17-нд Мэргэжлийн сумогийн 68 дахь их аварга Д.Дагвадорж өөрийн хөрөнгө оруулалтаар сумын Эрүүл мэндийн төвд шаардлагатай байсан түргэн тусламжийн PRADO автомашиныг өгсөн.</p> | <p>Бүрэн хэрэгжсэн<br/>100%</p> |  |
| 75.  | 108. | <p>Амьсгалын замын цочмог томуу, томуу төст өвчний дэгдэлттэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай<br/>2019.01.16 дугаар 31</p> <p>2. 2019 оны 1 дүгээр сарын 16-ны өдрөөс мөн оны 3 дугаар сарын 16-ны өдрийг хүртэлх хугацаанд 5 хүртэлх насны хүүхдээ 3-5 хоног асарсан ажил, хөдөлмөр эрхэлж байгаа эх, эцэг, асран хамгаалагчид цалинтай чөлөө олгохыг ажил олгогч нарт даалгасугай.</p>   | <p>Ажил олгогч байгууллагууд журмыг хэрэгжүүлж амьсгалын замын цочмог томуу, томуу төст өвчний дэгдэлттэй их байгаатай холбогдуулан 2019 оны 1 дүгээр сарын 16-ны өдрөөс мөн оны 3 дугаар сарын 16-ны өдрийг хүртэлх хугацаанд 5 хүртэлх насны хүүхдээ 3-5 хоног асарсан ажил, хөдөлмөр эрхэлж байгаа эх, эцэг, асран хамгаалагч 15 хүнд цалинтай чөлөө олгож, шийдвэрийг хэрэгжүүлсэн.</p>  | <p>Бүрэн хэрэгжсэн<br/>100%</p> |  |
| <b>12.2 Монгол Улсын Засгийн газрын хуралдааны тэмдэглэл</b> |      |   |  |                                 |  |
| 76.  | 109. | <p><b>2014 оны 2-р сарын 7-ны өдрийн дугаар 5</b></p> <p>Монгол Улсад донорын эгнээг өргөжүүлэх, донорын үйлсийг сурталчилах ажлыг холбогдох хуулийн дагуу зохион байгуулахыг бүх шатны Засаг дарга нарт даалгав.</p>   | <p>Эрүүл мэндийн төв донорын судалгааг шинэчилж идэвхтэй 34 донор бүртгэгдсэн. Жил бүр зохион байгуулагддаг донорын өдрөөр хүндэт 5 донор болон бусад идэвхтэй доноруудаа алдаршуулж, иргэд олон нийтэд таниулах ажлыг зохион байгуулсан. Мөн 1</p>  | <p>Бүрэн хэрэгжсэн<br/>100%</p> |  |

|                 |  |  |             |              |
|-----------------|--|--|-------------|--------------|
|                 |  | ахмад донорыг аймгийн ИТХурлын Хүндэт жуух бичгээр, 5 хүнийг сумын ИТХ, Улаан загалмайн нэрэмжит шагналаар шагнаж урамшуулсан. Бүх идэвхтэн донорууддаа гарын бэлэг гардуулж урам өгсөн. Донорын өдрийг сурталчилсан өдөрлөгт нийт 86 хүн хамрагдсан. Өдөрлөгт хүрэлцэн ирсэн иргэдэд Донорын талаар зохих мэдээлэл өгсөн. |             |              |
| Дундаж үнэлгээ  |  |  | <b>100%</b> |              |
| ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ |  |  |             | <b>96.6%</b> |

БАТАЛГААЖУУЛСАН:  
 ЗАСАГ ДАРГА М.ЖАМЪЯНШАРАВ

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:  
 ЗДТГ-ЫН ТЗАХ МЭРГЭЖИЛТЭН Г.ДОРЖХАНД